

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	5
УДИРТГАЛ	6
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	7
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	7
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	8
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг тогтоох	8
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох	10
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох	11
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	12
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	13
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	14
3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	14
3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	19
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ	44
ТАВ. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	47

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АНУ	Америкийн нэгдсэн улс
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МТА	Монголын татварын алба
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗХАШШ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НӨАТСТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч
НХАТ	Нийслэл хотын албан татвар
ОСБ	Оршин суугч бус
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТТ	Татвар төлөгч
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ҮХЭХ	Үл хөдлөх эд хөрөнгө
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрөн хадгаламжийн төв
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах Герман улс
ХГ	Хялбаршуулсан горим
ХК	Хувьцаат компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХОАТтХ	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
ЦХХ	Цалин хөдөлмөрийн хөлс

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт	9
Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт	9
Хүснэгт 3. “Үнэлгээний харьцуулах хэлбэрийн тайлбар”	11
Хүснэгт 4. Бусад орлого (2020-2023 он)	14
Хүснэгт 5. ХХОАТТХ-ийн 26.2-т заасны дагуу ногдуулсан албан татвар (2021-2023 он)	15
Хүснэгт 6. Хувь хэмжээ тогтоосон аймгууд	16
Хүснэгт 7. Албан татварын хувь хэмжээ, өөрчлөлт	17
Хүснэгт 8. Албан татварын шатлал	17
Хүснэгт 9. Шаталсан хувь хэмжээгээр албан татвар ногдуулсан мэдээлэл, тэрбум төгрөгөөр	18
Хүснэгт 10. Хувь хүний орлогын албан татвар төлөгчийн тоо, ногдлын мэдээ, тэрбумаар (2020-2023 он)	20
Хүснэгт 11. Бусад улсын туршлага	21
Хүснэгт 12.	21
Хүснэгт 13. Иргэдээс ирүүлсэн ХХОАТТХ-д заасан татварын хувь, хэмжээтэй холбоотой санал	Error! Bookmark not defined.
Хүснэгт 14. Үйл ажиллагааны орлого тайлагнасан иргэдийн тайлангийн нэгтгэл мэдээлэл /ТТ-06, ТТ-06-ХГ/	23
Хүснэгт 15. ХХОАТ-ын хүсэлт ирүүлсэн татвар төлөгчийн тоо	23
Хүснэгт 16. Үйл ажиллагааны орлогын албан татварын хувь хэмжээ, бусад улсын туршлага	25
Хүснэгт 17. Албан татварын чөлөөлөлтөд хамрагдсан иргэд, давхардсан тоогоор (2020-2023 он)	27
Хүснэгт 18. ХХОАТ-аас чөлөөлөгдсөн орлогын мэдээлэл (сая төгрөг), 2023 он	28
Хүснэгт 19. ХХОАТ-ын чөлөөлөлтөд хамрагдсан иргэдийн тоон харьцуулалт (2020-2023 он)	29
Хүснэгт 20. ХХОАТ-аас чөлөөлөгдсөн орлого, сая төгрөгөөр (2020-2023 он)	30
Хүснэгт 21. Тайлагнасан нийт татвар ногдох орлого ба татвар чөлөөлөгдөх орлого тэрбум төгрөгөөр, (2020-2023 он)	30
Хүснэгт 22. Албан татварын чөлөөлөлттэй холбоотой бусад улсын туршлага	32
Хүснэгт 23. Монгол Улсын ХХОАТ-ын тухай хуульд заасан цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод үзүүлэх хөнгөлөлт	34
Хүснэгт 24. ХХОАТ-аас хөнгөлөлт эдэлсэн орлогын мэдээлэл (сая төгрөг), 2023 он	36
Хүснэгт 25. Албан татварын хөнгөлөлттэй холбоотой бусад улсын туршлага	39
Хүснэгт 26. Бүртгэлд хамрагдсан татвар төлөгчийн тоо	42
Хүснэгт 27. Хугацаанд нь ирүүлсэн тайлангийн тоо, ногдол эзлэх хувиар (2023.12.31-ны өдрийн байдлаар)	43
Хүснэгт 28. Хугацаа хоцроосон тайлангийн тоо, эзлэх хувь (2023.12.31-ны өдрийн байдлаар)	43

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Нийт ХХОАТ-т эзлэх цалин болон шууд бус орлогоос суутгасан татварын хувь хэмжээ (2020-2023 он)	18
График 2. Хувь хүний орлогын албан татварт эзлэх орлого, тэрбум төгрөгөөр (2020-2023 он)	20
График 3. Албан татварын чөлөөлөлтөд хамрагдсан иргэд ба НӨАТ-ын урамшууллын орлого /харьцуулалт/	27
График 4. Албан татварын чөлөөлөлтөд хамрагдсан иргэд ба НӨАТ-ын урамшууллын орлого /харьцуулалт/.....	31
График 5. Албан татвараас чөлөөлөгдсөн орлогод НӨАТ-ын урамшууллын эзлэх хувийн жин, сая төгрөгөөр (2020-2023 он)	30
График 6. Хөнгөлөгдсөн албан татварын дүн, сая төгрөгөөр (2020-2023 он).....	35

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т татвартай холбоотой 17 чиглэл тусгагдсан байна.

Тус хөтөлбөрийн 3.2.1.2-т “Татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулна” гэж, мөн 3.2.1.4-т “....Бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах бодлого баримтална...” гэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 152 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4 дэх хэсгийн “Чинээлэг Монгол”-ын 1.10-т “Татварын шинэ хуулийг хэрэгжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ” гэж тус тус заажээ.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зохицуулалтууд нь татварын тогтолцоог сайжруулах, бага, дунд орлоготой иргэдэд ирэх татварын ачааллыг бууруулах, тодорхой хэмжээний хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх замаар татварт хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна.

Энэхүү зохицуулалтуудыг хэрэгжүүлэхийн тулд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан “Албан татварын хувь хэмжээ”, Тавдугаар бүлэгт заасан “Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт”-ийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, хувь хүний орлогын төрлөөс хамаарч албан татварын хувь хэмжээг олон улсын сайн туршлагад нийцүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг оновчтой, зорилтот бүлэгт чиглэсэн байдлаар хуульчлах гэх мэт асуудлууд үүсээд байна.

Учир нь иргэд, нийгмийн тодорхой бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой зарим асуудлын хүрээнд эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасаар байна.

Татварын шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх зайлшгүй шаардлагатай байна. Ингэснээр татварын хуулийн хэрэгжилтийн бодит байдал дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх боломжтой.

Иймд Татварын Ерөнхий газраас “Татварын ерөнхий хууль”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”, “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль”, “Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль”, “Газрын төлбөрийн тухай хууль”-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт тус тус үнэлгээг хийлээ.

Тус судалгаагаар Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /цаашид “ХХОАТтХ” гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан хэсэгчлэн үнэлгээ хийж, судалгааны тайланг боловсрууллаа.

Энэхүү судалгааны зорилго нь хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

ХХОАТТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Татвар хууль тогтоомжтой холбоотой асуудлууд олон нийтийн анхаарлын төвд үргэлж байдаг. Учир нь татвар нь тухайн хүний хүсэл зоригоос үл хамаарч заавал биелүүлэх шинжтэй буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долоо дугаар зүйлийн 1.3-т “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” нь Монгол Улсын иргэний биелүүлэх үндсэн үүрэг байхаар хуульчилсан.

Шинэчлэн найруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2019 оны 03 дугаар сарын 22-ний өдөр батлагдаж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус хуульд нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Хэдийгээр шинэчлэн найруулсан ХХОАТТХ хэрэгжиж эхлээд 5 жилийн хугацаа өнгөрч байгаа боловч тус хуулийн зарим зохицуулалтыг практикт нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, олон нийтээс тус хуультай холбоотой санал, шүүмж нэлээд ирсээр байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан, мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан татварын эрх зүйн орчны шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлэх шаардлагатай үүсээд байна.

Түүнчлэн, тус хуулийн зарим зүйл, заалтын хувьд аргачлалын 3.2-т заасан ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалттай байх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй, практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн талаар иргэд, нийгмийн бүлэг, төрийн бус байгууллагаас үндэслэл бүхий саналууд ирсээр байна.

Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийснээр татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдал, хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх хувилбарыг тодорхойлох боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, хуулиар зохицуулсан харилцаа нь зорилгодоо хүрсэн эсэх

болон практик хэрэгжилтийг судлан хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо оновчтой байгаа эсэх, хариуцлагын тогтолцоо үүргээ гүйцэтгэж байгаа эсэх, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл шинэчлэн батлах шаардлага бий эсэхийг тогтоох боломжтой.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Өөрөөр хэлбэл, үнэлгээ хийх болсон шалтгаан (өмнө тодорхойлсон)-тай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ.

Үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх нь чухал. Хуулийг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал ихэвчлэн хэт өндөр гардаг тул зөвхөн тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, маргаан дагуулж буй эрх зүйн хийдэл, давхардал, хоёрдмол утгатай, иргэд, олон нийтийн зүгээс шүүмжлэл дагуулж буй зохицуулалтуудыг сонгон авах нь зүйтэй хэмээн үзсэн болно. Энэ хүрээнд ХХОАТтХ-ийн албан татвар ногдох орлого тэр дундаа “бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого”-той холбоотой зохицуулалт, мөн албан татварын хувь, хэмжээ, албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, тайлан хүргүүлэх хугацаатай холбоотой зохицуулалтуудыг сонгон авч хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхээр тогтлоо.

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу ХХОАТтХ-ийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. “Зорилгод хүрсэн түвшин”

2. “Практикт нийцэж байгаа байдал”

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

ХХОАТтХ-ийн 1 дүгээр зүйлд тус хуулийн зорилгыг “...хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино...” гэж тодорхойлжээ. Иймд тус хуулийн дээр дурдсан зорилгыг хангахад чиглэсэн зүйл, заалтуудыг сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсэг	12.1.3.бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого.
2.	21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг	21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна.

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг. Иймд судалгааны энэ хэсэгт “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тус хуулийн зарим зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг /15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг/	21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна. 21.3. Энэ хуулийн 15.6-д заасан орлогын дүнд 1 хувиар албан татвар ногдуулна. 15.6. Хувь хүн өөрөө хүсэлт гаргаж, уг хүсэлтийг харьяа татварын алба бүртгэж авсан бол түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.
2.	22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	22.1. Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө: 22.1.1. хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж; 22.1.2. хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого; 22.1.3. гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд үзүүлж байгаа тусламж; 22.1.5. Засгийн газар, нийслэл, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз;

		22.1.6. Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого; 22.1.7. нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлого; 22.1.8. энэ хуулийн 5.9-д заасан хувь хүний цалин, нэмэгдэл; 22.1.9. энэ хуулийн 22.1.8-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний гадаад улсад олсон орлого. 22.1.10. гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.																
3.	23 дугаар зүйл	<table><tr><th>Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/</th><th>Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/</th></tr><tr><td>0-6 000 000 хүртэл</td><td>240 000</td></tr><tr><td>6 000 000-12 000 000 хүртэл</td><td>216 000</td></tr><tr><td>12 000 000-18 000 000 хүртэл</td><td>192 000</td></tr><tr><td>18 000 000-24 000 000 хүртэл</td><td>168 000</td></tr><tr><td>24 000 000-30 000 000 хүртэл</td><td>144 000</td></tr><tr><td>30 000 000-36 000 000 хүртэл</td><td>120 000</td></tr><tr><td>36 000 000 ба түүнээс дээш</td><td>-</td></tr></table> 23.3. Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар ипотекийн зээлийн хөрөнгөөр хувьдаа, анх удаа орон сууц худалдан авсан бол албан татвар төлөгчид Монгол Улсын Засгийн газрын тодорхойлсон ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү хоорондын зөрүүд төлсөн дүнтэй тэнцэх хэмжээний албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ. 23.10. Аймаг, хот, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн энэ хуулийн 6.3.2-т заасан орлогод ногдох албан татварыг аймаг, хот, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд 90 хувиар хөнгөлнө.	Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/	0-6 000 000 хүртэл	240 000	6 000 000-12 000 000 хүртэл	216 000	12 000 000-18 000 000 хүртэл	192 000	18 000 000-24 000 000 хүртэл	168 000	24 000 000-30 000 000 хүртэл	144 000	30 000 000-36 000 000 хүртэл	120 000	36 000 000 ба түүнээс дээш	-
Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/																	
0-6 000 000 хүртэл	240 000																	
6 000 000-12 000 000 хүртэл	216 000																	
12 000 000-18 000 000 хүртэл	192 000																	
18 000 000-24 000 000 хүртэл	168 000																	
24 000 000-30 000 000 хүртэл	144 000																	
30 000 000-36 000 000 хүртэл	120 000																	
36 000 000 ба түүнээс дээш	-																	
4.	27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	27.1. Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1, 20.4-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.																

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Хүснэгт 3. “Үнэлгээний харьцуулах хэлбэрийн тайлбар”

№	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1.	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2.	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.
4.	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

Судалгааны явцад ХХОАТХ-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ байх ёстой болон одоо байгаа, хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших, тохиолдол судлах харьцуулах хэлбэрийг аль тохирохыг ашиглана. Мөн гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт, сайн туршлагыг судлан үзсэн болно.

Судалгааны явцад хууль тогтоомжоос сонгон авсан зохицуулалтын “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэхэд буюу хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулах харьцуулалтын хэлбэрийг ашиглав.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн сонгон авсан хэсэгт тохируулан дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсрууллаа:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХХОАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтад заасан албан татвар ногдох орлоготой холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. ХХОАТХ-ийн 21 дүгээр зүйлд заасан албан татварын хувь, хэмжээтэй холбоотой зохицуулалт зорилгодоо эсэх. /21 дүгээр зүйлийн 21.1, 21.2.5, 21.3 дахь хэсгийн хүрээнд/

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХХОАТХ-ийн 21 дүгээр зүйлд заасан албан татварын хувь хэмжээтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. ХХОАТХ-ийн 22 дугаар зүйлд заасан албан татварын чөлөөлөлттэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. ХХОАТТХ-ийн 23 дугаар зүйлд заасан албан татварын хөнгөлөлттэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. ХХОАТТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан албан татварын тайлан хүргүүлэх хугацаатай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийг томьёолох хүрээнд ХХОАТТХ-ийн үнэлэхээр сонгогдсон зүйл, заалт тус тус бүрийг шалгуур үзүүлэлтэд тохирсон таамаглал буюу асуулт тавьж товч, тодорхой томьёолох зарчим баримтлан ажиллалаа.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, томьёолсон шалгуур үзүүлэлтүүдээс хамаарч тоон болон чанарын мэдээлэл ашиглан хуулийн хэрэгжилттэй холбоотой ямар мэдээлэл олж авахаа тодорхойлсон болно.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор тухайн асуудлын хүрээнд гаргасан ном, сурах бичиг, гарын авлага, судалгааны тайлан, уулзалт, хэлэлцүүлгийн үр дүн, холбогдох байгууллагаас судалгаа мэдээлэл авах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах арга:

- Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
- Холбогдох субъектээс судалгаа авах аргыг сонгон хэрэгжүүллээ.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон татварын эрх зүйтэй холбогдох сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, судалгааны тайлан, статистик мэдээ зэргийг цуглуулж үнэлгээ хийхэд ашиглав.

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд ХХОАТТХ-ийн зарим зохицуулалттай холбоотойгоор тухайн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд салбарын төлөөлөл, албан хаагчид, иргэд олон нийтээс судалгаа авч, холбогдох байгууллагаас үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатны гол зорилго нь хэрэгцээтэй, шаардлагатай байгаа ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулан судалснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох юм.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, судалгааны тайланг ашигласан болно.

Тухайлбал,

Хууль тогтоомж, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2019), №23;
- Татварын ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2019), №22;
- Төсвийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2012), №03;
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”;
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн дугаар 181 тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;

Бусад эх сурвалж

- “Татварын шинэчлэл-2025” олон нийтийн санал, асуулга, хэлэлцүүлгийн нэгтгэл мэдээ
- TABLEAU, Татварын мэдээ судалгаа, статистикийн нэгдсэн систем
- П.Одгэрэл, Татварын эрх зүйн ерөнхий анги /Захиргааны ерөнхий хууль ба Татварын ерөнхий хууль/, 2017 он;
- Татварын тогтолцоо /Тэргүүн дэвтэр/, 2002 он;

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн сонгосон зүйл, заалтуудыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэллээ.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХХОАТТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтад заасан албан татвар ногдох орлоготой холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Үнэлгээ:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “...Энэ хуулийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино...” гэж заажээ. Үүнээс үзвэл, тус хуулийн зорилгод хувь хүний орлогод албан татвар ногдуулах асуудал хамаарч байна.

Тус хуулийн 6 дугаар зүйлд албан татвар ногдох орлогыг хуульчилж өгсөн. Энэ зүйлийн 6.3-т “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:” гэж заасан бөгөөд 6.3.6-д “бусад орлого” гэж тус тус заажээ.

Бусад орлого гэдэгт тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-12.1.3-т заасан орлогыг хамааруулан ойлгоно. Үүнд:

- 12.1.1. урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого;
- 12.1.2. төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлого;
- 12.1.3. бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого тус тус хамаарч байна.

Хүснэгт 4. Бусад орлого (2020-2023 он)

Орлогын төрөл	2020		2021		2022		2023	
	ТТТоо	Нийт дүн	ТТТоо	Нийт дүн	ТТТоо	Нийт дүн	ТТТоо	Нийт дүн
12.1.1 тэрбумаар	19,516	13.6	14,833	13.7	30,933	22.0	45,734	32.8
12.1.2 тэрбумаар	507	0.3	1,274	1.7	4,491	2.6	30,314	116.3
12.1.3 төгрөгөөр	-	-	59	-	17	1,828,700	272	184,024,939

Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т заасан зохицуулалтын дагуу 2023 онд 184,024,939 хүнд албан татвар ногдуулж төвлөрүүлсэн байна. Дээрх тоон мэдээнээс үзвэл, тус хуулийн 12 дугаар зүйлд заасан бусад орлогын 3 төрлөөс 12.1.3-т заасан бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлогоос албан татвар ногдуулсан тохиолдол хамгийн бага байна. Иймд тус зохицуулалтыг нарийвчлан судлан үзлээ.

Бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч гэдгийг тус хуулийн 4.1.3-т “...ажлын байр,лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй худалдаа, үйлчилгээ, зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч хувь хүнийг...” ойлгохоор тодорхойлжээ.

Өөрөөр хэлбэл, бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч гэдэгт:

- Тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн;

- Хувиараа зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн;
- Ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн хамаарна.

Харин энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т “Энэ хуулийн 21.4-т заасан бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь уг зөвшөөрлийг гэрчилгээний хамт олгон, тухай бүр албан татварыг хураан авч, холбогдох төсөвт төвлөрүүлнэ” гэж заажээ. Тус зохицуулалтаас харвал, эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоно. Ийнхүү зөвшөөрөл олгохдоо уг зөвшөөрлийг гэрчилгээний хамт олгож, тухай бүр албан татварын хураан авч, холбогдох төсөвт тусгахаар зохицуулсан байна.

Гэвч тус зохицуулалтын дагуу төсөвт 2022, 2023 онд нийт 185,853,699 төгрөг тусгасан байна.

**Хүснэгт 5. ХХОАТтХ-ийн 26.2-т заасны дагуу ногдуулсан албан татвар
(2021-2023 он)**

Он	Зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага	ТТТоо	Ногдуулсан албан татвар
2021	59	-	-
2022	185	17	1,828,700
2023	310	272	184,024,939

Дээрхээс хүснэгтээс харвал, тус зохицуулалтын дагуу татвар төлөгчийн тоо маш бага байгаа бөгөөд үүнээс шалтгаалан ногдуулсан албан татварын хэмжээ бага байна.

ХХОАТтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 26 дугаар зүйлийн 26.2-д заасны дагуу зөвшөөрөл олгох аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын тамгын газрын эрх бүхий этгээд нь ТТ-32 тайланг гаргах бөгөөд тус хуулийн 21.4-т зааснаар аймаг, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоосон хязгаарт багтаан төлсөн албан татвар болон татвар төлөгч бүрээр тайлан /цаашид “тайлан” гэх/-г дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж, харьяа татварын албанд хүргүүлэх үүрэгтэй байдаг.

Өөрөөр хэлбэл, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын тамгын газрын эрх бүхий этгээд нь дээрх зохицуулалтын дагуу хүлээсэн үүргээ дараах байдлаар хэрэгжүүлэхээр байна:

- Татварын төрлөөр бүртгүүлнэ;
- Тайлант хугацаанд бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан хувь хүнээр ХХОАТтХ-ийн 24 дүгээр зүйлд заасан хязгаарт багтаан тогтоосон хэмжээгээр албан татварыг төлбөрийн даалгавар үүсгэн төлүүлнэ.
- Цахим тайлангийн системийн албан татвар төлсөн гэрчилгээ цэсэд татвар төлсөн бүртгэл болон гэрчилгээ үүсгэнэ.

Энэ нь тус зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байгааг илэрхийлж байна. Тус зохицуулалт хэрэгжилт хангалтгүй байгаа нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалж байна. Тухайлбал:

- ХХОАТтХ-ийн 26.2-т “...Энэ хуулийн 21.4-т заасан...” буюу тус хуулийн 21.4-т “...Энэ хуулийн 12.1.3-т заасан орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл доор дурдсан хязгаарт багтаан тогтооно...” гэж заасан боловч ИТХ нь бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй улмаас тус заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Учир нь одоогоор нийслэлд тус албан татварын хувь, хэмжээг тогтоогоогүй, орон нутагт 21 аймгаас 18 аймагт хувь, хэмжээг баталсан боловч хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.

Хүснэгт 6. Хувь хэмжээ тогтоосон аймгууд

№	Аймаг	Баталсан он, сар өдөр
1	Архангай	2021.12.02.
2	Баянхонгор	2019.11.29.
3	Баян-Өлгий	2019.12.03.
4	Булган	2019.12.05.
5	Говь-Алтай	2019 он
6	Говьсүмбэр	2020.01.27.
7	Дархан-Уул	2023.02.10.
8	Орхон	2020.01.17.
9	Өвөрхангай	2019.12.02.
10	Өмнөговь	2021.08.25.
11	Сэлэнгэ	2020.09.21.
12	Төв	2019.12.05.
13	Увс	2022.09.30.
14	Ховд	2019 он
15	Хөвсгөл	2021.01.22.
16	Хэнтий	2020 он
17	Завхан	2022.12.06.
18	Сүхбаатар аймаг	2019.12.04.

Энэхүү зохицуулалтын дагуу 2019 онд 8, 2020 онд 4, 2021 онд 3, 2022 онд 2, 2023 онд 1 аймгийн ИТХ хуульд заасан хувь хэмжээг тогтоох тухай тогтоол гаргасан байна. Харин нийслэлийн 9 дүүрэг, орон нутагт 3 аймаг энэхүү хувь хэмжээг тогтоогоогүй байна.

Гэвч хувь хэмжээ тогтоосон аймгуудын хувьд ч ХХОАТХ-ийн 12.1.3-т заасан албан татвар ногдох орлоготой холбоотой зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй хэвээр байгаа нь бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан хүн, аваагүй хүн хоёрын эрх зүйн байдал ижил байгаатай холбоотой байж болох юм.

Учир нь тус зөвшөөрлийг авсан хүн албан татвар төлөх бол тус зөвшөөрлийг аваагүй хүн албан татвар төлөхгүй ч тухайн хүнд хариуцлага оногдуулах зохицуулалт байхгүй байгаагаас шалтгаалан энэхүү зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй, зорилгодоо хүрэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар “Бичил худалдаа, ажил үйлчилгээ эрхлэгч” буюу ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1.0-50.0 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний, хувиараа зорчигч, эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж буй хувь хүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5.0-100.0 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний хувь хүний орлогын албан татварыг сар бүр ногдуулахаар хуульчилсан боловч тухайн заалт нь хэрэгжилт хангалтгүй, зорилгодоо хүрч чадаагүй байна.

Шалгуур үзүүлэлт 2. ХХОАТХ-ийн 21 дүгээр зүйлд заасан албан татвар хувь, хэмжээтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Төсвийн тухай хуулийн төслийг дагалдах хуулийн төслүүдийн хамт өөрчлөлт оруулан баталсан бөгөөд **орлогын тэгш бус байдлыг бууруулах зорилгоор**¹ шаталсан татварын тогтолцоог нэвтрүүлэхээр Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан.

Энэ хүрээнд тус хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн нэг нь 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан зохицуулалт юм.

Хувь хүний орлогын албан татвар хэрэгжиж эхэлснээс хойш цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шууд бус орлогод орлогын хэмжээнээс хамааран хувь хэмжээг шатлалтайгаар 2-45% -иар оногдуулж ирсэн байна.

Хүснэгт 7. Албан татварын хувь хэмжээ, өөрчлөлт

Татварын төрөл	1993-1997	1997-2004	2004-2007	2007-2019	2023 оноос
Цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого	6 шатлалтай	3 шатлалтай	3 шатлалтай	Шатлалгүй	3 шатлалтай
Хувь	2,5,15,27,40,45	10,20,40	10, 20, 30	10	10, 15, 20
Шууд бус орлого	6 шатлалтай	3 шатлалтай	3 шатлалтай	Шатлалгүй	3 шатлалтай
Хувь	2,5,15,27,40,45	10,20,40	10, 20, 30	10	10, 15, 20

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтаар цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шууд бус орлогод шаталсан татварын тогтолцоо дараах хэлбэрээр хэрэгжиж байна.

Хүснэгт 8. Албан татварын шатлал


Жилийн орлого (₮)	Татварын хэмжээ (%)
0-120 сая (сарын 0-10 сая)	10%
120-180 сая (сарын 10-15 сая)	12 сая төгрөг дээр нэмэх нь 120 сая төгрөгөөс дээш давсан орлогод 15%
180 сая төгрөгөөс дээш (сарын 15 сая төгрөгөөс дээш)	21 сая төгрөг дээр нэмэх нь 180 сая төгрөгөөс дээш давсан орлогод 20%

ХХОАТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах явцад 2021 оны татварын нэгтгэсэн тайлангийн дүнд тулгуурлан цалин ба түүнтэй адилтгах орлого олсон 817,238 иргэнээс 99.9 хувь нь 10 сая төгрөгөөс доош татвар ногдуулах цалингийн орлоготой, байгаа учир нийт цалингийн орлого бүхий иргэдийн 0.1 хувьд нөлөөлөх² судалгааг Сангийн яамнаас гаргасан байна.

¹ ХХОАТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга.

² Мөн тэнд.

График 1. Нийт ХХОАТ-т эзлэх цалин болон шууд бус орлогоос суутгасан татварын хувь хэмжээ (2020-2023 он)



Дээрх графикаас харахад цалин хөлсний орлогын хувийн жин 2020-2023 онд харьцангуй тогтвортой байгаа нь харагдаж байна. Нийт төвлөрүүлсэн ХХОАТ-ын дүнд цалин хөлс, түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын хувийн жинг харьцуулбал цалин хөлс 76.8-79.7 хувийг эзэлж байхад шууд бус орлого 1.0-1.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 9. Шаталсан хувь хэмжээгээр албан татвар ногдуулсан мэдээлэл, тэрбум төгрөгөөр

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

Татварын алба		Мөр	Нийт			
Шатлал			Нийт	120 сая хүртэлх	120-180 сая хүртэлх	180 саяас дээш
Суутгуулсан иргэдийн тоо /давхардсан/			1,205,586	1,199,236	3,192	3,158
Татвар ногдох орлого	Хуулийн 7.1.1	1	16,789.10	15,224.40	471.5	1,093.20
	Хуулийн 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7	2	274.9	252.4	7.3	15.2
	Хуулийн 7.1.6	3	305.5	288.4	5.4	11.6
	Нийт (1+2+3)	4	17,369.50	15,765.20	484.2	1,120.10
ЭМД, НДШ	ЭМД, НДШ Дүн (Хуулийн 7.1,1-5, 7.1,7)	6	1,664.00	1,618.30	22.9	22.8
	ЭМД, НДШ Дүн (Хуулийн 7.1,6)	7	50.6	50.3	0.1	0.2
Хуулийн 7.1-д заасан орлогод татвар ногдуулах орлого (4-6-7)		8	15,677.40	14,119.10	461.2	1,097.20
Албан татвар ногдох шууд бус орлого	Орлого	10	162	120.1	5.3	36.6
Нийт татвар ногдуулах орлого /8+10/		11	15,838.90	14,238.70	466.5	1,133.70
Хуулийн 7.1.1, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод Ногдуулсан татвар	Хуулийн 7.1.1, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод Ногдуулсан татвар	13	1,605.80	1,385.90	49.6	170.3
	Хуулийн 23.1-т заасан хөнгөлөлт нийт	16	115.4	115.4	0	0
Хуулийн 7.1-д заасан орлогод ногдуулсан Хөнгөлөлтийн дараах татварын дүн		17	1,490.40	1,270.50	49.6	170.3
Хуулийн 7.1.6-д заасан орлогод ногдуулсан дүн		18	28.5	26.1	0.6	1.8
Шууд бус орлогод ногдуулсан албан татвар		19	19.8	12	0.6	7.1
Нийт суутгуулсан албан татварын дүн		20	1,538.70	1,308.60	50.8	179.3

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үед буюу 2021 онд 120 сая төгрөгөөс доош цалин ба түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлого тайлагнасан 869,191 иргэн, 120 сая төгрөгөөс 180 сая төгрөг хүртэлх орлого тайлагнасан 1,525 иргэн, 180 сая төгрөгөөс дээш орлого тайлагнасан 1,266 иргэн байсан бол 2023 онд 120 сая төгрөгөөс доош цалин ба түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлого тайлагнасан 922,960 иргэн, 120 сая төгрөгөөс 180 сая төгрөг хүртэлх орлого тайлагнасан 3,715 иргэн, 180 сая төгрөгөөс дээш орлого тайлагнасан 3,144 иргэн болж өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 10. Цалин ба түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлого

2021 он			
1. 120 сая хүртэл	2. 120-180 сая	3. 180-аас дээш	Нийт
869,191	1,525	1,266	817,200
2023 он			
1. 120 сая хүртэл	2. 120-180 сая	3. 180-аас дээш	Нийт
922,960	3,715	3,144	929,819

Энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлт нь олон улсын жишигт нийцсэн, орлогын тэгш бус байдлыг бууруулах зорилгодоо хүрсэн, практикт амжилттай хэрэгжиж байна гэж үзэхээр байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХХОАТТХ-ийн 21 дүгээр зүйлд заасан албан татварын хувь хэмжээтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хүн амын орлогод өөрчлөлт бий болж, иргэдийн шинэ төрлийн орлогыг татварт хамруулах, татварын системийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгын үүднээс 1993 оны 01 дүгээр 01-ний өдөр Хүн амын орлогын албан татварын тухай хуулийг баталсан. Тус хуулийг 2 удаа шинэчлэн найруулсан бөгөөд одоогийн дагаж мөрдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх болсон.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй ХХОАТТХ-д албан татвар төлөгч, суутган төлөгч, албан татвар ногдох орлого, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, албан татварын хувь хэмжээ, албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, албан татвар ногдуулах, төсөвт төлөх, тайлагнах харилцааг орлогын эх үүсвэр тус бүрээр хэрхэн тодорхойлох, тогтоосон орлогод албан татвар ногдуулах хувь хэмжээ тодорхой бөгөөд тухайн орлогыг хэн, хэзээ, хэрхэн тайлагнаж төлөх асуудал нь дэс дараатай ойлгомжтой байна.


Монгол Улсын ХХОАТТХ-д дараах эх үүсвэр бүхий орлогод албан татвар ногдуулж байна. Үүнд:

1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;
2. Үйл ажиллагааны орлого;
3. Хөрөнгийн орлого;
4. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;
5. Шууд бус орлого;
6. Бусад орлого.

2020 онд 3,215,400 иргэн 1,042.3 тэрбум төгрөг, 2021 онд 2,385,59 иргэн 1,108.4 тэрбум төгрөг, 2022 онд 1,968,556 иргэн 1,385.5 тэрбум төгрөг, 2023 онд 2,350,484 иргэн 1,956.3 тэрбум төгрөгийн албан татварыг бусдад суутгуулсан болон өөрөө тайлагнаж

төлсөн байна. /2020 онд Эрдэнэс таван толгой ХК ногдол ашгийн орлого олгож, тайлагнасан учир тоо огцом өсөлттэй байна./

График 2. Хувь хүний орлогын албан татварт эзлэх орлого, тэрбум төгрөгөөр (2020-2023 он)



Дээрхээс дүгнэвэл, цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, хөрөнгийн болон хөрөнгө борлуулсны орлого зэрэг татварыг суутган төлөх тогтолцоогоор хэрэгжүүлж буй орлогын эх үүсвэрт ногдуулж буй татварын гүйцэтгэл өндөр, хэрэгжилт сайн, харин иргэн өөрөө тодорхойлж тайлагнах зохицуулалт бүхий /жишээлбэл үйл ажиллагааны орлого/ төрлөөр хангалтгүй байгаа дүр зураг харагдаж байна.

Цалин хөлс, түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын хувийн жинг харьцуулбал ХХОАТ-ын нийт дүнд цалин хөлс 76.8-79.7 хувийг эзэлж байхад шууд бус орлого 1.0-1.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 10. Хувь хүний орлогын албан татвар төлөгчийн тоо, ногдлын мэдээ, тэрбумаар (2020-2023 он)

Он	Татвар ногдох орлого тайлагнасан		Татвар ногдуулах орлого тайлагнасан		Татвар төлөхөөр тайлагнасан		Татварын орлогод эзлэх хувь
	Татвар төлөгчийн тоо	орлогын дүн	Татвар төлөгчийн тоо	тайлагнасан дүн	Татвар төлөгчийн тоо	ногдлын дүн	
2020	3,224,630	15,309.7	3,224,619	11,897.4	3,215,400	1,042.3	12%
2021	2,391,210	17,116.8	2,390,631	12,446.7	2,385,539	1,108.4	15%
2022	1,974,312	20,964.4	1,972,772	15,645.6	1,968,556	1,385.5	15%
2023	2,352,921	26,792.1	2,352,514	20,943.0	2,350,484	1,956.3	14%

Дээрхээс үзэхэд 2023 онд нийт 2,352,921 хувь хүн 26,792.1 тэрбум албан татвар ногдох орлого, 2,352,514 хувь хүн 20,943.0 тэрбум албан татвар ногдуулах тайлагналын мэдээ ирүүлсэн бөгөөд 2,350,484 хувь хүн 1,956.3 тэрбум төгрөг татвар төлөхөөр тайлагнасан байна.

Олон улсын туршлага:

Цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлоготой холбоотой татварын хувь хэмжээг бусад улс оронд хэрхэн тодорхойлсон талаар судлан үзсэн. Энэ хүрээнд 8 улсын шаталсан татварын хувь хэмжээг судлахад гадаадын ихэнх улс орнууд “Олсныхоо хэрээр

төл” гэсэн татварын бодлогыг баримталдаг байна. Улс орнуудын цалин хөдөлмөрийн хөлсний орлогод ногдох татварын хувь хэмжээг харуулбал:

Хүснэгт 11. Бусад улсын туршлага

д/д	Улс	Орлогын төрөл	Хувь хэмжээ
1	Америкийн Нэгдсэн Улс	Цалин хөдөлмөрийн хөлсний орлого	10%, 12%, 22%, 24%, 32%, 32%, 37%
2	Канад Улс		15%, 20.5%, 26%, 29%, 33%
3	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс		0%, 14%-42%, 45%
4	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс		0%, 20%, 40%, 45%
5	Австрали		0%, 16%, 30%, 37% 45%
6	Бүгд Найрамдах Франц Улс		0%, 11%, 30%, 41%, 45%
7	Шведийн Хаант Улс		10%, 28%, 34%, 57%
8	Бразил Улс		0%, 7.5%, 15%, 22.5%

1. Франц улс хувь хүний орлогын албан татварын хувь, хэмжээг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс инфляцтай уялдуулан 4.8 хувиар нэмэгдүүлсэн байна. Мөн татварыг тодорхойлохдоо гэр бүлийн коэффициентыг ашиглаж нийт орлогоос хасагдах зардлыг хассан дүнг ганц бие хүний хувьд 1, хүүхэдгүй гэр бүл 2, 2 хүүхэдтэй гэр бүл 2.5-д хуваагаад гарсан дүнгээс шатлалын дагуу татварыг тодорхойлдог байна.

Татвар төлөгчид орлогоосоо шалтгаалан сар, улирлаар урьдчилгаа төлбөрөөр татвараа төлж болдог. Франц улс 2019 оноос эхлэн ажил олгогчид ажилчдын цалингийн орлогоос татварыг суутган, төлдөг системийг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь 1 удаад төлөх их хэмжээний татварын ачааллыг багасгахад чиглэсэн байна. Татварын хувь хэмжээг орлогын хэмжээнээс хамааран 0-45 хувиар тогтоодог байна.

Хүснэгт 12. Франц улсын татвар ногдох орлого

Татварын хувь	Татвар ногдох орлогын дүн
0%	€11,294 хүртэл
11%	€11,295-аас €28,797 хүртэл
30%	€28,798-аас €82,341 хүртэл
41%	€82,342-аас €177,106 хүртэл
45%	€177,106-аас дээш

2. Сингапур улсад хувь хүний орлогын албан татварыг тус улсад байнга оршин суугч, оршин суугч бус татвар төлөгчийн татварын хувь хэмжээг тэнцүүлэх зорилгоор 2024 онд дээд хэмжээг 22%-с 24% болгон өөрчилсөн байна.

Байнга оршин суугч татвар төлөгчийн төлөх албан татварын хувь хэмжээ:

Татварын дээд хэмжээ: 2014-2016 онд 20%

2017-2023 онд 22%

2024 оноос 24% болон нэмэгдсэн байна.

3. *Шинэ Зеланд улсын хувьд* хувь хүний орлогын албан татварын шаталсан хувь хэмжээг хэрэглэдэг бөгөөд 2024 оны долоо дугаар сарын 31-ээс орлогын албан татварын босгоо дараах байдлаар нэмэгдүүлсэн байна. Татвар ногдох орлогын дүнгээс хамаарч 10.5 %-иас 39 % хувиар 5 шатлалтайгаар тогтоосон байна.

Дээрхээс дүгнэвэл, хувь хүний орлогод шаталсан хувь хэмжээгээр татвар ногдуулах нь олсон орлогын хэмжээтэй уялдсан, орлогын тэгш бус байдлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, татварын системийг хялбаршуулах, засгийн газраас үзүүлэх үйлчилгээг санхүүжүүлэх зорилготой. Орлогын хэмжээнээс үл хамааран ижил хувь хэмжээгээр татвар ногдуулах нь бага орлоготой иргэдэд илүү их нөлөөллийг үзүүлдэг. Албан татварыг ялгавартай тогтоох нь бага орлоготой иргэдэд үлдэх зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээнд зарцуулах мөнгөний хэмжээг илүү их байлгаснаар эдийн засгийг эрчимжүүлэх болно.

Шаталсан хувь хэмжээг хэрэглэх нь дараах давуу болон сул талтай байна.

Давуу тал:

- **Тэгш эрх:** Өндөр орлоготой хүмүүс илүү татвар төлдөг бөгөөд энэ нь орлогын дахин хуваарилалтыг үнэлдэг нийгмийн хувьд илүү шударга гэж тооцогддог.
- **Олон нийтэд үзүүлэх үйлчилгээг санхүүжүүлэх чадвар:** Шаталсан татварын систем нь олон нийтэд үзүүлэх үйлчилгээ, халамжийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд чиглэгдэнэ.
- **Тэгш бус байдлын эсрэг авч буй арга хэмжээ:** Өндөр орлоготой хүмүүс орлогынхоо илүү хувийг бага орлоготой хүмүүсээс илүү төлдөг учраас орлогын тэгш бус байдлыг багасгахад тусалдаг.

Сул тал:

- **Нарийн төвөгтэй:** Олон шатлалт татварын систем нь дагаж мөрдөхөд төвөгтэй байж болно.
- **Хөрөнгийн орлогын татвар:** Зарим системд хөрөнгө оруулалтаас олсон орлогыг (хүү, ногдол ашиг)-д олсон орлогоос бага хэмжээгээр татвар ногдуулах нь өндөр орлоготой хүмүүст ашигтай байж болно.

Монгол улсын хууль тогтоомжоор цалин, хөдөлмөрийн хөлсний орлогод ногдуулж буй хувь хэмжээ олон улсын дунджаас харьцангуй доогуур бөгөөд өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөлд тохирсон байна гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл энэхүү зохицуулалт практикт нийцэж буй боловч хүлээн зөвшөөрөгдөх байдлын хувьд зарим асуудал байгаа нь иргэдээс ирүүлж буй санал, шүүмжээс харагдаж байна.

Түүнчлэн, тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т “Энэ хуулийн 15.6-д заасан орлогын дүнд 1 хувиар албан татвар ногдуулна” гэж заасан бөгөөд мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д “Хувь хүн өөрөө хүсэлт гаргаж, уг хүсэлтийг харьяа татварын алба бүртгэж авсан бол түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно” гэж заажээ.

Энэхүү зохицуулалт нь бизнес эрхлэгч иргэнийг дэмжих, татварын орчныг хялбаршуулах, зорилгоор хуульчлагдсан бөгөөд 2019 оны татварын шинэчлэлээр хувиараа бизнес эрхлэгчийн тайлангаар баталгаажсан албан татвар ногдох орлого нь 50 сая төгрөгөөс хэтрээгүй тохиолдолд татварын хялбаршуулсан горимоор үйл ажиллагааны нийт орлогын 1 хувиар албан татвар төлж, жилд нэг удаа тайлан гаргах боломжтой болсон.

Хуульд орсон энэ өөрчлөлт тайлагналыг хялбаршуулах эерэг нөлөөлөлтэй байх боловч нөгөө талаасаа зардлын баримтжуулалт шаардахгүй болсноор цахим төлбөрийн баримт /и-баримт/ олголтын үзүүлэлт буурах дам сөрөг нөлөөлөлтэй байна.

Татварын хуулийн шинэчлэлийн үр дүнд нийт хувиараа бизнес эрхлэгч хувь хүний орлогын албан татварын тайлагналт 2019 онд 7 хувь байсан бол 2022 онд 28 хувь болж өссөн ба тэдгээрийн 59 хувь нь хялбаршуулсан горимоор тайлагнасан байна. Үүнээс үзвэл хувь хүний орлогын албан татварын тайланг хялбаршуулсан горимоор тайлагнах сонголтыг хувиараа бизнес эрхлэгчдэд олгосон шийдвэр нь татварын тайлагнал, хамрагдалт, бүртгэлд эерэг нөлөө үзүүлсэн болох нь харагдаж байгаа ч хувиараа бизнес эрхлэгчдийн

72 хувь нь татвараа тайлагнахгүй хэвээр байгаа нь тодорхой хэмжээний далд эдийн засгийг бүрдүүлж байна.

Хүснэгт 13. Үйл ажиллагааны орлого тайлагнасан иргэдийн тайлангийн нэгтгэл мэдээлэл /ТТ-06, ТТ-06-ХГ³

Он	ТТ тоо	Үйл ажиллагааны орлого (тэр.₮)	Үйл ажиллагааны орлогод ногдох татварын ногдол (тэр.₮)	Төлөлт (тэр.₮)	ХХОАТ-Энгийн тайлан				ХХОАТ-Хялбаршуулсан тайлан			
					Тайлан ирүүлсэн иргэдийн тоо	Үйл ажиллагааны орлого (тэр.₮)	Үйл ажиллагааны орлогод ногдох татварын ногдол (тэр.₮)	Төлөлт (тэр.₮)	Тайлан ирүүлсэн иргэдийн тоо	Үйл ажиллагааны орлого (тэр.₮)	Үйл ажиллагааны орлогод ногдох татварын ногдол	Төлөлт (тэр.₮)
2020	104,045	2763.3	14.7	13.3	29,988	2,411.1	11.2	10.0	74,057	352.2	3.5	3.3
2021	97,831	3,682.9	21.7	19.6	44,521	3,246.8	17.3	15.4	53,310	436.1	4.4	4.3
2022	120,092	4,530.8	35.9	32.9	49,482	3,681.6	27.4	24.8	70,610	849.2	8.5	8.1
2023	125,944	5,169.1	53.8	50.9	55,311	3,923.2	41.3	39.3	70,633	1,245.9	12.5	11.6

Монгол Улсын 2023 онд Төсвийн тухай хуулийг дагаж өргөн мэдүүлсэн тус хуульд нэмэлт, өөрчлөлт орж хувиараа бизнес эрхлэгчдийн татвар тайлагнах, төлөх үйл ажиллагааг хялбаршуулан, далд эдийн засгийг бууруулах зорилгоор орлогын босго хамаарахгүй бүх хувиараа бизнес эрхлэгч, татвар төлөгч хувь хүн өөрийн хүсэлтээр хялбаршуулсан горимыг сонгож, үйл ажиллагааны орлогоо тайлагнах боломжийг олгох хуулийн төслийг баталсан.

Хүснэгт 14. ХХОАТ-ын хялбаршуулсан горим сонгож тайлагнах хүсэлт ирүүлсэн татвар төлөгчийн тоо

Он	ХХОАТ-ын ХГ-ын хүсэлт ирүүлсэн ТТТоо	
	Илгээсэн	Зөвшөөрсөн
2020 онд	801	489
2021 онд	13207	10338
2022 онд	24773	20956
2023 онд	38255	31909
2024 онд	57731	48903
Нийт	134767	112595

Дээрхээс дүгнэвэл, 2024 онд татвар төлөгч хувь хүн өөрийн хүсэлтээр хялбаршуулсан горимыг сонгож үйл ажиллагааны орлогоо тайлагнах нийт 57731 хүсэлт илгээсэн нь өмнөх онтой харьцуулахад 19476 буюу 50.9 хувиар нэмэгдсэн байна. Мөн 2024 онд нийт илгээсэн 57731 хүсэлтийн 48903 буюу 84.1 хувийг зөвшөөрсөн байна.

Хуулийн төслийн анхны үзэл баримтлалд хувиараа бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүнийг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагнах ажиллагааг хялбарчлах зорилгоор хялбаршуулсан татварын тайлагналын болон 1 хувиар албан татвар тооцож төлөх заалтуудыг хуулийн төсөлд тусгасан.

³ Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн 2024.01.28-ны өдрийн мэдээлэл

Хуульд бүх төрлийн орлогод албан татвар төлөхөөр хувь хэмжээг тогтоосон боловч цалин хөдөлмөрийн болон үйл ажиллагааны орлогод ногдох хувь хэмжээ зөрүүтэй, мөн цалин хөдөлмөрийн хөлсний орлого нийт ХХОАТтХ-ийн орлогын 76-78 хувийг бүрдүүлж байхад үйл ажиллагааны орлого 19 хувийг бүрдүүлж байгаа нь татварын шударга байх зарчимд нийцэхгүй байна.

Татварын албанд иргэн, хуулийн этгээдээс 2021 онд төлбөрийн баримт олгоогүй гэх 43,266 гомдол, 2022 онд 33916 гомдол, 2023 онд 24337 гомдол, 2024 онд 18336 гомдол ирүүлсэн байна. Энэ нь Үйл ажиллагааны орлогоор албан татвар төлөгч бизнес эрхлэгчид хасагдах зардалгүйгээр борлуулалтын орлогоос 1 хувиар албан татвар төлөх болсонтой холбоотойгоор орлогоо бага болгох, нуун дарагдуулах зорилгоор борлуулалтад төлбөрийн баримт олгохгүй байх сөрөг нөлөө үүсгэж байгааг илтгэж байна.

2019 оны хуулийн төслийн үзэл баримтлалд хувиараа бичил бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүнийг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагнах ажиллагааг хялбарчлах зорилгоор хялбаршуулсан татварын тайлагналын болон 1 хувиар албан татвар тооцож төлөх заалтуудыг хуулийн төсөлд тусгасан.

Дараах үр дагаврыг үүсгэж байна:

1. Хуульд бүх төрлийн орлогод албан татвар төлөхөөр хувь хэмжээг тогтоосон боловч цалин хөдөлмөрийн болон үйл ажиллагааны орлогод ногдох хувь хэмжээ зөрүүтэй, мөн цалин хөдөлмөрийн хөлсний орлого нийт ХХОАТтХ-ийн орлогын 76-78 хувийг бүрдүүлж байхад үйл ажиллагааны орлого 19.0 хувийг бүрдүүлж байгаа нь татварын шударга байх зарчмыг хангахгүй байна.

2. Татварын албанд иргэн, хуулийн этгээдээс төлбөрийн баримт олгоогүй гэх 43,266 гомдол, 2022 онд 33916 гомдол, 2023 онд 24337 гомдол, 2024 онд 18336 гомдол ирүүлсэн байна. энэ нь Үйл ажиллагааны орлогоор албан татвар төлөгч бизнес эрхлэгчид хасагдах зардалгүйгээр борлуулалтын орлогоос 1 хувиар албан татвар төлөх болсонтой холбоотойгоор орлогоо бага болгох, нуун дарагдуулах зорилгоор борлуулалтад төлбөрийн баримт олгохгүй байх сөрөг нөлөө үүсгэж байгааг илтгэж байна.

Хувь хүний үйл ажиллагааны орлогын албан татварын хувь хэмжээтэй холбоотой асуудлыг АНУ, Канад, Их Британи, Австрали, ХБНГУ, Франц, Шинэ Зеланд, Япон улсад хэрхэн зохицуулдаг талаар судлан үзлээ.

**Хүснэгт 15. Үйл ажиллагааны орлогын албан татварын хувь хэмжээ
бусад улсын туршлага**

№	Улс	Үйл ажиллагааны орлогын албан татварын хувь хэмжээ
1.	АНУ	Татварын хувь хэмжээ: 15.3% байна. Хэрэв жилд 400 доллар ба түүнээс дээш орлого олвол уг орлогод татвар ногдуулна.
2.	Канад	Татварын хувь хэмжээ: 11.9% байна.
3.	Австрали	Татварын хувь хэмжээ: Австралид хувиараа бизнес эрхлэгчид олсон орлогоосоо хамаарч орлогын албан татвар төлөх ёстой. Австралид "бие даасан ажил эрхлэлтийн татвар" гэж байдаггүй ч орлогын албан татварыг ердийн орлогын албан татвар ногдуулдаг зарчмын дагуу ногдуулдаг. Татварын хаалт: 2023 онд хувь хүний татварын хувь хэмжээ орлогоос хамааран 0-45% хооронд хэлбэлздэг. Тэтгэвэр: Хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийг тэтгэврийн сандаа (тэтгэврийн хуримтлал) оруулахыг дэмждэг боловч 2023 онд 4 доллар болох тодорхой босго хэмжээнээс дээш орлого олохгүй бол энэ нь заавал байх шаардлагагүй.
4.	ХБНГУ	Хувь хэмжээ нь орлогоос хамааран 14% - 45% хүртэл байна.
5.	Франц	Францад хувиараа хөдөлмөр эрхлэгчид орлогын албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хамтад нь төлдөг. Орлогын албан татвар: Хувиараа бизнес эрхлэгчид орлогын албан татварыг нийт орлогоосоо тооцож, 0%-45% хүртэл төлдөг. Босго: Хэрэв та € 10,777 (хувь хүний орлогын үндсэн босго) -аас дээш орлого олбол орлогын албан татвар ногдуулна.
6.	Шинэ Зеланд	Татварын хувь хэмжээ: Шинэ Зеландад хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс орлогын түвшнээс хамааран 10.5% - 39% хооронд хэлбэлздэг стандарт татварын хувь хэмжээгээр орлогын албан татвар төлдөг. АСС (Ослын нөхөн олговрын корпорац): Хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс ажилтай холбоотой ослыг хамардаг АСС-д хувь нэмрээ оруулах шаардлагатай. Шимтгэлийн хувь хэмжээ нь бизнесийн үйл ажиллагаанаас хамаардаг боловч ерөнхийдөө ихэнх салбаруудын хувьд ойролцоогоор 1.39% байдаг.
7.	Япон	Татварын хувь хэмжээ: Японд хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд орлогоосоо хамаарч татвар төлдөг бөгөөд хөрөнгө орлогын мэдүүлгээ өгөх шаардлагатай. Орлогын албан татвар: Хувь хүний орлогоос хамааран хувь хүн 5%-45% хооронд хэлбэлздэг. Эрүүл мэнд, тэтгэврийн шимтгэл: Хувиараа хөдөлмөр эрхлэгчид Үндэсний эрүүл мэндийн даатгал, Үндэсний тэтгэврийн системээр дамжуулан эрүүл мэндийн даатгал, тэтгэврийн төлөвлөгөөнд хувь нэмэр оруулах ёстой. Босго: Хэрэв таны орлого 2023 онд 380,000¥ орчим байх үндэсний хөнгөлөлтөөс дээш байвал та татвараа мэдүүлэх ёстой.

Дээрхээс дүгнэвэл, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн татвар нь ерөнхийдөө орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг нь хамардаг бөгөөд хувь хэмжээ нь улс орон бүрд өөр өөр байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. ХХОАТХ-ийн 22 дугаар зүйлд заасан албан татварын чөлөөлөлттэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Үнэлгээ:

Хувь хүний орлогын албан татварын чөлөөлөлт нь татварын хуульд заасан тодорхой орлогын хэсгийг, эсвэл бүхэлд нь татвараас чөлөөлөх эрх зүйн арга хэмжээ юм. Харин хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт нь татвар төлөгчийн орлогоос тодорхой хэмжээний татварыг хасаж, бууруулах арга хэмжээ юм.

Хувийн орлогын албан татвар нь татвар төлөгч, хамрах хүрээ, татвар ногдох зүйл, хөнгөлөлт чөлөөлөлт, хувь хэмжээ гэсэн үндсэн бүтэцтэй байна.⁴

Монгол Улсын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Нийгэм хамгааллын;
- Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах;
- Боловсролыг дэмжих;
- Санхүүгийн зах зээлийг дэмжих;
- Бүс нутгийн хөгжлийг дэмжих гэсэн ерөнхий 5 чиглэлээр бодлого хэрэгжүүлж байна гэж үзэж болох юм.

Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйл 10.1-д “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт дараах хэлбэртэй байна.

- 10.1.1. ногдуулсан татварыг хорогдуулах;
- 10.1.2. татварын хувь, хэмжээг бууруулах;
- 10.1.3. тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээг татвараас чөлөөлөх;
- 10.1.4. татвар төлөгчийг татвараас чөлөөлөх;
- 10.1.5. татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх;
- 10.1.6. татварын хууль тогтоомжид заасан бусад.
- 10.2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулах бөгөөд хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. гэсэн ерөнхий зохицуулалттай бөгөөд харин салбар хуулиудаар тухайн төрлийн албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх харилцааг дэлгэрэнгүй зохицуулжээ.

Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.12-т татвар төлөгчийн эрхийн тухай “татварын хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх” гэж заасан бол 15 дугаар зүйлийн 15.1-д татварын ...хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх...хөөн хэлэлцэх хугацаа 4 жил байхаар, 29 дүгээр зүйлийн 29.5-д тайлагнах үүргийг “Хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгч татварын тайлан тушаах үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд уг татварын тайлан нь түүнийг тухайн төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах үндсэн баримт болно.” гэж заасан байна.

Дэлхийн банкны Төсвийн зардлын тойм судалгаанд Монгол Улсын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тоо их байгаа нь татвараас зайлсхийх арга зам болох эрсдэлтэй, мөн татварын бааз суурийг хумьж буйг дурдсан байдаг.

Манай улсын ХХОАТТХ-ийн 5 дугаар бүлэгт ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд тус хуулийн 22 дугаар зүйлд нийт 9 төрлийн орлогыг татвараас чөлөөлөхөөр, харин 23 дугаар зүйлд 13 төрлийн орлогод ногдсон албан татварыг тодорхой хувиар хөнгөлөхөөр заажээ.

Өөрөөр хэлбэл, манай улсад 2024 оны байдлаар ХХОАТ-ын 21 төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалт хүчин төгөлдөр үйлчилж байна.

ХХОАТТХ-ийн 22 дугаар зүйлд албан татвараас чөлөөлөхөөр заасан 9 төрлийн орлогоос 2020-2023 онд тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т “гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд үзүүлж байгаа тусламж” гэж, 22.1.8-д “энэ хуулийн 5.9-д заасан хувь хүний цалин, нэмэгдэл” гэж, 22.1.9-д “энэ хуулийн

⁴ Мөн тэнд, 102 дахь тал.

22.1.8-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний гадаад улсад олсон орлого” гэж, мөн зүйлийн 22.1.10-т “гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого” гэж заасан дээрх 4 үндэслэлээр албан татвараас чөлөөлөгдсөн орлогын талаар мэдээлэл байхгүй.


Дээрхээс дүгнэвэл, 2020-2023 онд албан татвараас чөлөөлөх 9 төрлийн орлогоос иргэд 5 төрлийн орлого олж албан татварын чөлөөлөлтөд хамрагдсан байна.

Хүснэгт 16. Албан татварын чөлөөлөлтөд хамрагдсан иргэд, давхардсан тоогоор (2020-2023 он)

Утга	2020 он	2021 он	2022 он	2023 он
Чөлөөлөлтөд хамрагдсан иргэн /давхардсан тоо/	4,095,196	4,793,817	4,735,535	5,193,644
НӨАТ-ын урамшуулал	4,094,502	4,780,365	4,734,813	5,191,487
НӨАТ-ын урамшууллын эзлэх хувь	99,98	99,72	99,98	99,96


2023 онд албан татварын чөлөөлөлтөд давхардсан тоогоор нийт 5,193,644 иргэн хамрагдсанаас 5,191,487 нь НӨАТ-ын урамшууллын орлогод хамаарч чөлөөлөлтөд хамрагдсан бол үлдсэн 2157 нь хуульд заасан бусад 4 үндэслэлээр албан татвараас чөлөөлөгдсөн байна.

График 3. Албан татварын чөлөөлөлтөд хамрагдсан иргэд ба НӨАТ-ын урамшууллын орлого /харьцуулалт/



Албан татварын чөлөөлөлтөд хамрагдсан иргэний тоо, хувийн жингээр авч үзвэл ХХОАТ-ын чөлөөлөлт эдэлсэн нийт иргэдийн дийлэнх буюу 99.72-99.98 хувь нь нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлого гэх үндэслэлээр албан татвараас чөлөөлөгдсөн иргэд байна.

**График 4. Албан татварын чөлөөлөлтөд хамрагдсан иргэд ба
НӨАТ-ын урамшууллын орлого /харьцуулалт/**



Хуульд заасан бусад 8 үндэслэлээр /Үүнээс 4 үндэслэлээр албан татвараас чөлөөлөгдсөн орлого бүртгэгдээгүй/ орлогыг албан татвараас чөлөөлөх зохицуулалтад хамрагдсан иргэд 2020 онд 0,02 хувь, 2021 онд 0,28 хувь, 2022 онд 0,02 хувь, 2023 онд 0,04 хувийг тус тус эзэлж байна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дамжуулан олон төрлийн бодлого арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой ба цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос дараах орлогууд ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдаж байна.

Хүснэгт 17. ХХОАТ-аас чөлөөлөгдсөн орлогын мэдээлэл (сая төгрөг), 2023 он

№	ХХОАТ-аас чөлөөлөгдсөн орлогын мэдээлэл	Татвар төлөгчийн тоо	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж.	1,434	57,170.9
2	Хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого	666	41,051.5
3	Гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд үзүүлж байгаа тусламж;	0.0	0.0
4	Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг (бонд)-ийн төлбөр, хүү, анз	27	148.1
5	Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого	30	1,191.3
6	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлого; /ТТ-ийн тоо давхардсан дүнгээр/	5,191,487	345,873.8
7	Энэ хуулийн 5.9-д заасан хувь хүний цалин, нэмэгдэл; /Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн салбарт томилогдон ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн	0.0	0.0

	нь Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчид хамаарахгүй./		
8	Энэ хуулийн 22.1.8-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний гадаад улсад олсон орлого.	0.0	0.0
9	Гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.	0.0	0.0

2022 онд нийт 4,735,535 иргэний 393,9 тэрбум төгрөгийн татвар ногдох орлогыг ХХОАТ-аас чөлөөлсөн байна. Харин 2023 онд нийт 5,193,644 иргэний 445,4 тэрбум төгрөгийн татвар ногдох орлогыг ХХОАТ-аас чөлөөлсөн нь өмнөх онтой харьцуулахад татвар төлөгчийн тоо 458,109 буюу 9,6 хувиар, татвар ногдох орлого 51,5 тэрбум буюу 13.1 хувиар тус тус өссөн байна.

Татварын хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж, хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогын чөлөөлөлт нь нийт ХХОАТ-аас чөлөөлөгдсөн орлогын 12.8 хувийг эзэлж байна.

ХХОАТтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан албан татвараас чөлөөлөх 9 үндэслэлээс тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.6 заалтуудыг нарийвчлан судлан үзэхэд дараах байдал тогтоогдсон. Үүнд:

1. Энэ хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т “Гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд үзүүлж байгаа тусламжийн орлогыг” албан татвараас чөлөөлөхөөр заасан бөгөөд хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш энэ заалтын дагуу чөлөөлөгдсөн орлогын талаар мэдээлэл байхгүй.

2. Энэ хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6-д “Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого” гэж заажээ.

Харин тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т “газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;” гэж заасан бөгөөд энэхүү зохицуулалтад тусгагдсан “биет бус хөрөнгө борлуулсан шилжүүлсний орлого” гэдгийг тус хуулийн 10.2-т “Биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар төлөгч өөрийн эдийн бус хөрөнгө өмчлөх эрхийг хуульд заасны дагуу бусдад шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна.” гэж тайлбарлан зохицуулжээ.

ХХОАТтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.6-д албан татвараас чөлөөлөгдөхөөр заасан “Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого”-ыг тус хуулийн 10.3-т шинээр “Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн бол энэ хуулийн 10.1.2-т заасан орлогод хамаарахгүй” гэж зохицуулан, тус хуулийн 22.1.6-д заасан зохицуулалтыг хасах нь оновчтой байна. Ингэж өөрчилснөөр хуулийн заалт, зохицуулалтын уялдаа бүрэн хангагдаж найруулгын хувьд илүү оновчтой болох юм.

Хүснэгт 18. ХХОАТ-ын чөлөөлөлтөд хамрагдсан иргэдийн тоон харьцуулалт (2020-2023 он)

Он	Нийт			НӨАТ урамшуулал		
	Нийт	Өсөлт	Өсөлт /бууралт/-ийн хувь	Нийт	Өсөлт /бууралт/	Өсөлт /бууралт/-ийн хувь
2020	4,095,196.00			4,094,502		
2021	4,793,817.00	698,621.00	17.1	4,780,365	685,863	16.8
2022	4,735,535.00	-58,282.00	-0.1	4,734,813	-45,552	-1.0
2023	5,193,644.00	458,109.00	9.7	5,191,487	456,674	9.6


2021 онд албан татварын чөлөөлөлтөд хамрагдсан иргэдийг өмнөх онтой харьцуулахад 17,1 хувь өссөн бол 2022 онд 0,1 хувь буурсан, харин 2023 онд 9,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 19. ХХОАТ-аас чөлөөлөгдсөн орлого, сая төгрөгөөр (2020-2023 он)

Утга	2020 он	2021 он	2022 он	2023 он
Нийт чөлөөлөгдсөн орлого	194,872.70	326,755.80	393,886.50	445,435.60
НӨАТ урамшуулал	177,867.10	221,693.30	275,350.40	345,873.80
Бусад орлого	17,005.60	105,062.50	118,536.10	99,561.80
22.1.7 /НӨАТ урамшуулал-хувь/	91.27	67.85	69.91	77.65

2020-2023 онд ХХОАТ-аас чөлөөлөгдсөн нийт орлогын хэмжээ тогтмол өссөн байна. Тухайлбал, 2023 оны нийт чөлөөлөгдсөн орлогыг өмнөх онтой харьцуулахад 51,5 тэрбум төгрөг буюу 13,1 хувь өссөн үзүүлэлттэй байх бөгөөд нийт чөлөөлөгдсөн орлогын 77,65 хувь нь НӨАТ-ын урамшууллын орлого байна.

График 5. Албан татвараас чөлөөлөгдсөн орлогод НӨАТ-ын урамшууллын эзлэх хувийн жин, сая төгрөгөөр (2020-2023 он)



2020-2023 онд ХХОАТ-ын нийт чөлөөлөгдсөн орлогын дийлэнх хувийг ХХОАТтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.7-д “Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлого” эзэлж байна. Тухайн онуудад нийт чөлөөлөгдсөн орлогын дунджаар 76,67 хувь нь нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлого байна.

Хувь хүний орлогын төрөлд хамаарах нийт тайлагнасан орлогын дүнд чөлөөлөгдсөн орлогын дүн, эзлэх хувийг тооцож үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 20. Тайлагнасан нийт татвар ногдох орлого ба татвар чөлөөлөгдөх орлого тэрбум төгрөгөөр, (2020-2023 он)

Утга	2020 он	2021 он	2022 он	2023 он
Тайлагнасан нийт татвар ногдох орлого	15,309.7	17,116.8	20,964.4	26,792.1
Үүнээс албан татвараас чөлөөлөгдсөн орлого	194.9	326.8	393.9	445.4
Хувь	1.27	1.91	1.88	1.66

2020-2023 онд тус хуулийн 22 дугаар зүйлд заасан албан татвараас чөлөөлөхтэй холбоотой 9 төрлийн орлогын албан татвараас 4 төрлийн орлогын албан татварт чөлөөлөлт эдлээгүй харин чөлөөлөлт эдэлсэн үлдсэн 5 төрлийн орлогын албан татварын зохицуулалтаас тус хуулийн 22.1.7-д заасан “нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлого” гэх үндэслэлд нийт албан татвараас чөлөөлөгдсөн иргэдийн 99,9 хувь нь, нийт албан татвараас чөлөөлөгдсөн орлогын 76,67 хувь нь хамаарч байна.

Тус хуулийн 22.1.10-т “гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого”-ыг албан татвараас чөлөөлөхөөр заасан бөгөөд энэ заалтыг 2023 оны 12 дугаар сард хуульд оруулсан, үр дагавар нь 2024 оны тайлан нэгтгэгдэж дууссаны дараа л харагдах учир аливаа үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй юм.

Хувь хүний орлогын албан татварын чөлөөлөлттэй холбоотой асуудлыг Франц, Сингапур, Шинэ Зеланд, Словени, Финланд, АНУ, БНСУ, Болгар улсад хэрхэн зохицуулдаг талаар судлан үзлээ.

Хүснэгт 21. Албан татварын чөлөөлөлттэй холбоотой бусад улсын туршлага

Д/д	Улс	Татвараас чөлөөлөх орлогын төрөл /Тоо/
1	Франц	1. Мэргэжлийн орлого олохтой холбоотой зардал 2. Хөдөлмөр эрхлэлтийн зардал /тэтгэврийн хуримтлал/ 3. Олгосон тэтгэмж 4. Гэр бүлийн зардал 5. Хүүхэд асрах зардал /нэг хүүхдэд ногдох зардлын дээд хэмжээ 3500 евро хүртэл/ 6. Орон сууцтай холбоотой 7. Өв залгамжлал, хандив тусламжийн зардал
		1. Цагаачлалын урамшуулал /Франц улсад мэргэжлийн үйл ажиллагаа явуулахтай шууд холбоотой нэмэлт төлбөр / 2. Ажил олгогчийн гадаадад явуулсан үйл ажиллагаатай холбоотой хэсэг /цалин/ 3. Хөдлөх хөрөнгөөс олсон гадаад эх үүсвэрийн орлогын 50%; 4. гадаад эх үүсвэрээс олсон оюуны болон үйлдвэрлэлийн өмчийн тодорхой бүтээгдэхүүний орлогын 50%; 5. гадаадын үнэт цаасны борлуулалт болон компанийн эрхийн орлогын 50%
2	АНУ	1.Хүүхдийн тэтгэмж /бага насны болон насанд хүрсэн/ 2. Эцэг эх, өвөө, эмээдээ олгосон тэтгэмж 3.Салсан эхнэр/нөхөртөө олгосон тэтгэмж 4.Өндөр настай хүнд тусламж үзүүлсэн зардал /75-аас дээш насны хүнд хоол хүнс, орон сууцны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлсэн зардал/
3	Сингапур	1.Бага орлоготой буюу 20,000 Сингапур доллароос доош орлоготой иргэдийг албан татвараас чөлөөлнө 2.Гэр бүлтэй холбоотой зардал 3.Гадаадад хөдөлмөр эрхлэхтэй холбоотой зардал 4.Ахмад настнуудад үзүүлсэн тусламж 5.Зарим төрлийн мэргэжил, гарааны бизнесийг татвараас чөлөөлнө.
4	Өмнөд Солонгос	1. Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх 2. Татварын хөнгөлөлт 3. Тусгайлсан суутгал, тэтгэмж 4. Зарим төрлийн хөрөнгийн орлогын чөлөөлөлт 5. Бага орлоготой иргэдийн албан татварын хөнгөлөлт 6. Зарим гадаад иргэдийг албан татвараас чөлөөлөх

5	Шинэ Зеланд	1.\$14,000-с доош орлоготой иргэдийн албан татварын хувь 10,5% байна. 2.Ажилтны KiwiSaver буюу тэтгэврийн хөнгөлөлтийн дансанд 3%-ийг хуримтлуулдаг. 3.Бага, дунд орлоготой гэр бүлүүдэд үзүүлэх хөнгөлөлт /хүүхэд өсгөх зардлыг бууруулахад зориулсан/ 4.Хувиараа бизнес эрхлэгчдийн татвар ногдох орлогыг бууруулах, зардалд тооцох 5.Орон сууцны зээлийн хүүгийн хасалт 6.Хүүхэд харах үйлчилгээний дэмжлэг 7.Зарим төрлийн албан татвараас чөлөөлөх 8.Гэр бүл, хамааралтай этгээдэд үзүүлсэн тусламж 9.Хөрөнгийн орлогын албан татвараас чөлөөлөх 10.Оршин суугч бус татвар төлөгчийг зарим төрлийн албан татвараас чөлөөлдөг
6	Словени	1. цалин, хөдөлмөр хөлс, 2. үйл ажиллагааны орлого /бизнесийн/, 3. хөрөнгийн орлого, 4. түрээсийн орлого, 5. тэтгэмж, 6. бусад орлого
7	Финланд	Бага орлоготой хүмүүст зориулсан татварын хөнгөлөлт Тогтоосон хязгаараас доогуур орлоготой иргэдийг албан татвараас чөлөөлнө. 1 хүнд 17,000 орчим еврогийн хөнгөлөлт үзүүлнэ.
8	Болгар	1. Татварын жилийн хугацаанд худалдах, солилцохоос олсон орлого: худалдан авсан өдрөөс эхлэн худалдах, солих хооронд гурваас дээш жил өнгөрсөн бол нэг үл хөдлөх орон сууц 2. Хөдлөх эд хөрөнгийг худалдах, солилцохоос олсон орлого, үүнд: худалдан авсан өдрөөс худалдах, солих хугацаа нэг жилээс бага бол зам, агаарын хөлөг, усан тээврийн хэрэгсэл; 3. Урлагийн бүтээл, цуглуулга, эртний эдлэл; 4. хувьцаа, хувьцаа, нөхөн төлбөрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын бонд болон бусад санхүүгийн хөрөнгө, түүнчлэн гадаад валютын арилжааны орлого; 5. санхүүгийн хэрэгслийг захиран зарцуулах орлого; 6. шинэ хувьцаа, хувьцаа хэлбэрээр хуваарилагдсан арилжааны компаниудын ашиг буюу өөрийн хөрөнгийн бусад эх үүсвэр, түүнчлэн одоо байгаа хувьцаа, хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх хэлбэрээр хуваарилагдсан ашиг буюу өөрийн хөрөнгийн бусад эх үүсвэр; 7. нөхөн олговор олгох хэрэгсэл, хөрөнгө оруулалтын бондыг худалдсан, солилцсоны улмаас эрх зүйн актын дагуу нөхөн төлбөр авсан этгээдийн орлого; 8. Болгар эсвэл гадаадад албан журмын даатгалын орлого; 9. нэмэлт тэтгэвэр авах эрх олж авсны дараа сайн дурын нэмэлт даатгалын орлого; даатгалын гэрээгээр хүлээн авсан техникийн нөөцийн хөрөнгө оруулалтаас олсон орлого; даатгуулагчийн хувийн дансанд байршуулсан тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгийн хөрөнгө оруулалтаас олсон орлого; 10. Европын холбооны гишүүн улс эсвэл Европын эдийн засгийн бүсийн хэлэлцээрт оролцогч өөр улсад байгуулсан хадгаламжийн хүүгийн орлого;

Дээрхээс дүгнэвэл, бусад улс орнууд ихэвчлэн гэр бүл, хувь хүний амьжиргааг дэмжих чиглэлээр бага орлоготой сегментэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж зарим орлогыг албан татвараас чөлөөлөх хуулийн зохицуулалттай байна. Эдгээр улсуудад ямар нэг үйл ажиллагаа, эсвэл бизнесийн чиглэлийг сонгон авч татвараас чөлөөлсөн зүйл байдаггүй нь татварын тэгш байх зарчмыг алдагдуулна гэж үздэгтэй холбоотой байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. ХХОАТТХ-ийн 23 дугаар зүйлд заасан албан татварын хөнгөлөлттэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Үнэлгээ:

Татвар гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг бүрдүүлэхэд зориулагдсан тухайн татвар төлж буй этгээдээс ямар нэгэн хариу шаардлага тавихгүйгээр гүйцэтгэх үүрэг бүхий мөнгөн төлбөр⁵ юм.

Татварын хамгийн эхний зорилго нь төрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг бий болгоход чиглэж ирсэн бол орчин үед зохицуулах, хянах, нийгмийн гэсэн хандлага руу чиглэж байна. Татварын тусламжтайгаар нийтийн буюу төрийн чиг үүргийг хэрэгжүүлж түүнд шаардагдах зардлыг санхүүжүүлдэг. Тухайлбал,

- Төрийн албан хаагчдыг цалинжуулах;
- Ялгаатай байдлыг арилгахын тулд нийгмийн ядуу хэсэг рүү чиглэсэн төрийн халамжийг санхүүжүүлэх;
- Соёлын арга хэмжээ болон эрдэм шинжилгээ судалгаа, боловсрол болон сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг дэмжих санхүүжүүлэх;
- Дэд бүтцийг барьж байгуулах, засаж сайжруулах, хадгалах хамгаалах ажиллагааг санхүүжүүлэх;
- Батлан хамгаалах цэрэг армийн зардлыг санхүүжүүлэх гэх мэт.⁶

Харин зохицуулах зорилго нь төр татвараар дамжуулан иргэдийн хувьд тодорхой аж ахуй эрхлэхийг дэмжих эсвэл хязгаарлах боломжтой байдаг.⁷

Татварын ерөнхий газар (ТЕГ)-аас ХХОАТ-ын зохицуулалтын үүргийг хангах мөн эдийн засгийн өндөр өсөлтийг тогтвортой хадгалах, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжиж, дундаж болон эмзэг давхаргын амьдралын доод түвшнийг (орон сууц, сурах, хөдөлмөр эрхлэлт гэх мэт) хангах, орлогын ялгаварт байдлыг багасгах зорилтын хүрээнд хувь хүний орлогын төрөл болон бараа, үйлчилгээг татвараас хөнгөлж, чөлөөлж байна.

ХХОАТТХ-ийн 23 дугаар зүйлд 13 төрлийн орлогод ногдох албан татварын тодорхой хувиар хөнгөлөхөөр хуульчилжээ.

Хүснэгт 22. Монгол Улсын ХХОАТ-ын тухай хуульд заасан цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод үзүүлэх хөнгөлөлт

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ (төгрөг)	Хөнгөлөлтийн хэмжээ (төгрөг)
0 - 6,000,000 хүртэл	240,000
6,000,000 - 12,000,000 хүртэл	216,000
12,000,000 - 18,000,000 хүртэл	192,000
18,000,000 - 24,000,000 хүртэл	168,000
24,000,000 - 30,000,000 хүртэл	144,000
30,000,000 - 36,000,000 хүртэл	120,000
36,000,000 ба түүнээс дээш	-

⁵ П.Одгэрэл, Татварын эрх зүйн ерөнхий анги /Захиргааны ерөнхий хууль ба Татварын ерөнхий хууль/, 18 дахь тал.

⁶ Мөн тэнд, 15 дахь тал.

⁷ Мөн тэнд.

График 6. Хөнгөлөгдсөн албан татварын дүн, сая төгрөгөөр (2020-2023 он)



2020-2023 онд нийт хөнгөлөгдсөн албан татварын хэмжээ жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

2023 онд нийт хөнгөлөгдсөн албан татвар 194,372,95 сая төгрөг байснаас 115,377,10 сая төгрөг буюу 59,36 хувь нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод хамаарч байна.

Түүнчлэн, 2022 онд ХХОАТ-ын тайланг 322.1 мянган иргэн ирүүлснээс 55.6 мянган иргэн буюу 17.2 хувь нь татварын хөнгөлөлтөд хамрагдаж, 64.5 тэрбум төгрөгийн татварыг буцаан олгосон байна. Харин 2023 онд 302.7 мянган иргэн тайлан ирүүлснээс 54.2 мянган иргэн буюу 17.9 хувь нь татварын хөнгөлөлтөд хамрагдаж, 78.6 тэрбум төгрөгийн татварыг буцаан олгосон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад тайлан ирүүлсэн татвар төлөгч 19,363 буюу 9.6 хувиар, хөнгөлөлт эдэлсэн татвар төлөгч 1,393 буюу 2.5 хувиар тус тус буурсан бол буцаан олгосон дүн 14,096.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тухайлбал, 2023 онд хувьдаа анх удаа орон сууц худалдан авсан болон барьсан 35,331 иргэнд 69.3 тэрбум төгрөг, төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн сургалтын төлбөр төлсөн 18,844 иргэнд 9.3 тэрбум төгрөгийн татварын буцаан олголтыг тус тус олгосон байна.

Үүнээс төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн сургалтын төлбөр төлсөн иргэдэд олгосон татварын буцаан олголтыг хэр үр ашигтай бөгөөд хүртээмжтэй олгосныг энгийн тооцоолол хийж үзэхэд:

2023 оны байдлаар 145,345 суралцагч их, дээд сургууль, коллежид суралцдаг ба үүнээс 18,844 суралцагч буюу 12.9 хувь нь сургалтын төлбөрийн татварын буцаалт авах хүсэлт гаргасан бөгөөд нэг суралцагчийн дундаж сургалтын төлбөр 4.4⁷ сая төгрөг байна. Хэрэв бүх суралцагчид татварын буцаалт хүлээн авах хүсэлт гаргавал нийт 630.0 гаруй тэрбум төгрөгийн буцаан олголт шилжүүлэх шаардлагатай болно. Энэ нь 2023 онд олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн буцаалтаас ойролцоогоор 15 дахин их байна.

Хүснэгт 23. ХХОАТ-аас хөнгөлөлт эдэлсэн орлогын мэдээлэл (сая төгрөг), 2023 он⁸

№	ХХОАТ-аас хөнгөлөлт эдэлсэн орлогын мэдээлэл	Татвар төлөгчийн тоо	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулах албан татварын хөнгөлөлт	978,624	115,377.1
2	Донорын олговор, Даатгалын нөхөн төлбөр, Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагналын орлогод ногдох татварын хөнгөлөлт	0.0	0.0
3	Үр тариа, төмс, хүнсний ногоо, түүний үр, жимс жимсгэнэ, түүний үр, суулгац гэх мэт тэжээлийн ургамал, модны суулгац үйлдвэрлэсэн болон тариалсан аж ахуй нэгжийн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	59	92.4
4	Өөрийн хэрэгцээнд зориулан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксожсон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан бол баримтаар нотлогдож байгаа төлбөртэй тэнцэх орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	12	5.6
5	Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн баримтаар нотлогдож байгаа хандивтай тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	1	0.9
6	Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	0.0	0.0
7	Монгол Улсын иргэн хувьдаа, анх удаа орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авсан бол ийнхүү орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авахад зарцуулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	35,331	69,294.1
8	Татвар төлөгчийн төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон асран хамгаалагчаар тогтоогдсон асрамж, дэмжлэгт байгаа хүүхэд оюутан, эсхүл суралцагчаар элсэн суралцаж байгаа тохиолдолд түүний анхны бакалаврын болон дипломын мэргэжил эзэмших сургалтын хугацаанд тухайн татварын жилд төлсөн, баримтаар нотлогдож байгаа сургалтын төлбөртэй тэнцэх орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	18,844	9,357.4

Дээрх тоон мэдээллээс дүгнэвэл, 2023 онд нийт 1,032,871 иргэн 194,127,5 сая төгрөгийн албан татварын хөнгөлөлт эдэлсэн байна.

2022 онд нийт 1,283.2 мянган иргэний 191.1 тэрбум төгрөгийн татвар ногдох орлогод ХХОАТ-ын хөнгөлөлтийг олгосон бол 2023 онд 1,032.9 мянган иргэний 194.1 тэрбум төгрөгийн татвар ногдох орлогод ХХОАТ-ын хөнгөлөлтийг олгосон нь өмнөх онтой харьцуулахад 250.2 мянган татвар төлөгчөөр буюу 19.50 хувиар буурсан бол олгосон хөнгөлөлтийн дүн 3.0 тэрбум төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна.

2023 онд Мөнгөн дүнгээр тооцож үзэхэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох татварын хөнгөлөлт нь нийт хөнгөлөлтийн 59.4 хувийг бүрдүүлж байгаа бол цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод

⁸ ТЕГ-ын ТМБНС-ийн мэдээ, 2023 он.

ногдох татварын хөнгөлөлтөд хамрагдсан иргэд нийт хөнгөлөлтөд хамрагдсан иргэдийн 94.7 хувьтай тэнцэж байна.

Хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого нь хүн амын нийгмийн асуудлыг зохицуулахаас гадна татвараа үнэнч шударгаар өөрөө тодорхойлон төлөх байдлыг урамшуулах шаардлагатай байна. Гэвч дээрх тоон мэдээнээс үзэхэд Монгол Улсын хувьд ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт бусад улстай харьцуулахад олон боловч нийгмийн болон зохицуулалтын үүрэг зарим талаар биелдэггүй, тодорхой бүлгийн хүмүүст тайлангаа өөрөө мэдүүлэх хангалттай хөшүүрэг болж чадахгүй байна гэж судлаачдын зүгээс үзэж байна.

Нөгөөтээгүүр, нийгэм хувьсан өөрчлөгдөхийн хэрээр хувь хүний орлогын эх үүсвэрүүдийн төрөл өргөжин тэлж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд цахимаар олж буй орлогын төрлүүд нэмэгдэж байна. Үүнд:

- Цахим худалдаанаас олсон орлого (бараа бүтээгдэхүүн борлуулж буй цахим хаяг);
- Цахим сургалтаас олж буй орлого;
- Контент бүтээгчдийн орлого (цахим хаягаас олж буй орлого, зар сурталчилгаанаас олсон орлого) гэх мэт.

Түүнчлэн, Монгол Улсын ХХОАТ дахь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дүн шинжилгээ хийж үзэхэд:

- Татварын бааз суурь хангалтгүй;
- Ам бүлийн гишүүдийн тоо болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг тооцоогүй буюу өрхийн ам бүлийн тоо, ажил эрхэлж буй өрхийн гишүүний тоо, тэжээлгэгч иргэдийн тоо зэргийг харгалздаггүй;
- Татварын албаны мэдээллийн баазын чанар дутмаг;
- Хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого нь оновчтой биш, хэрэгжилт хангалтгүй;
- Хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой зохицуулалтын тоо бусад улстай харьцуулахад олон боловч нарийвчлан зохицуулж чадаагүй, тодорхой бус, оновчгүй гэх мэт асуудлууд үүсээд байна.

Харин ХХОАТ дахь үйл ажиллагааны орлогод албан татвар ногдуулах харилцаанд дүн шинжилгээ хийж үзэхэд:

- Үйл ажиллагааны орлогыг тодорхойлсон тодорхойлолт, нэр томьёо нь хэт өргөн цар хүрээг хамарсан ерөнхий бөгөөд тодорхой бус;
- Хялбаршуулсан горим нэвтрүүлснээр тайлагналыг хөнгөвчлөх алхам болсон ч цахим төлбөрийн баримт олголтод сөргөөр дам нөлөөлж эхэлсэн байна.
- Технологийн дэвшлийн улмаас өмнө байгаагүй, шинээр бий болсон орлогод хэрхэн татвар ногдуулах арга зүй байхгүй;
- Хувиараа бараа бүтээгдэхүүн борлуулах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх бизнесийн орлого буюу үйл ажиллагааны орлогод татвар ногдуулах үйл явц, хэрэгжилт хангалтгүй;
- Үйл ажиллагаа эрхэлдэг иргэд бүртгэлээ хэрхэн хөтөлж орлого, зардал, татвараа хэрхэн тодорхойлох нь тодорхойгүй, хангалттай мэдлэг, мэдээлэлгүй;
- Татвар төлөлтийг нэмэгдүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын хэрэгжилт хангалтгүй, зорилтот иргэддээ зориулсан зохицуулалт бага;
- ХХОАТ тайлан илгээх үйл явц нь суутган төлөгчийн орлогод ногдох албан татварыг тайлагнахад хялбар хэдий ч үйл ажиллагаа эрхлэгч, үл хөдлөх хөрөнгө (ҮХХ) түрээслүүлэгч болон бусад орлогыг тайлагнах үйл явц хүндрэлтэй, иргэдэд ойлгомжгүй.
- Ам бүлийн гишүүдийн тоо болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг тооцоогүй буюу өрхийн ам бүлийн тоо, ажил эрхэлж буй өрхийн гишүүний тоо, тэжээлгэгч иргэдийн тоо зэргийг харгалзан авч үзэх талаар зохицуулалт байхгүй.

Монгол Улс өнөөгийн байдлаар “Хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн өндөр өсөлтийг тогтвортой хадгалах, өсөлтийн үр дүнд дундаж давхаргын эзлэх хувийг нэмэгдүүлэх, хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжиж, нийгмийн орлого багатай дундаж болон эмзэг

давхаргын амьдралын доод түвшнийг (орон сууц, сурах, хөдөлмөр эрхлэлт гэх мэт) хангах, орлогын ялгаварт байдлыг багасгах зорилтын хүрээнд хувь хүний зарим орлогын төрөл болон бараа, үйлчилгээг татвараас хөнгөлж, чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлж байна”. Эдгээр зорилтын хэрэгжилтийг харгалзан авч үзвэл:

Хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжих. Хүний хөгжил, боловсролыг дэмжих зорилгоор сургалтын төлбөртэй тэнцэх орлогод албан татварын хөнгөлөлт эдлүүлдэг. Монгол Улсад 2023-2024 оны хичээлийн жилд нийт их, дээд сургууль, коллежийн 145,345 суралцагч²² суралцаж байгаагаас 2023 онд сургалтын төлбөрийн буцаан олголтыг 18,844 иргэнд олгосон байна.

Дундаж болон бага орлоготой өрх (орон сууц, сурах, хөдөлмөр эрхлэлт гэх мэт)-ийн амьжиргааг дэмжих. Тус зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ХХОАТ-ын бодлого, зохицуулалт нь зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний орлогод чөлөөлөлт үзүүлэхээс өөр зохицуулалт байхгүй байна. Харин орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд анхлан байр, хувийн орон сууц болон нийтийн орон сууц барих болон худалдан авахтай холбоотой гарсан зардлын нийт дүнтэй тэнцэх орлогод ногдох хөнгөлөлт үзүүлж байна. Олон улсын зарим туршлагаас харахад аливаа хөнгөлөлтөд нийгмийн сегмент, иргэдийн санхүүгийн нөхцөл байдал болон бусад харгалзах хүчин зүйлсийг авч үзсэнээр дундаж давхаргыг нэмэгдүүлэх, нийгмийн орлого багатай давхаргын амьдралын түвшнийг хангах болон орлогын ялгавартай байдлыг багасгах, эрчим хүчний хэмнэлттэй хувийн сууц барихад дэмжлэг болохуйц чиглэлийн татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлэх чиглэлийг түлхүү баримталж байна.

Орлогын ялгаварт байдлыг багасгах. Манай улсын орлогын тэгш бус байдлын индекс нь сүүлийн 28 жилийн турш 30.3-аас 35.8-ын хооронд хэлбэлзэж ирсэн буюу орлогын тэгш бус байдал сайжрахгүй байгаа нь нэг талаас тус зорилтын хэрэгжилтэд чиглэсэн бодлого, арга хэмжээ хангалтгүй байгааг илтгэж байна.

Монгол Улс дээрх зорилго, зорилтод хүрч чадахгүй байгаа нь эрх агуулагчдын эмзэг байдлыг оновчтой тодорхойлоогүй, иргэдийн санхүү болон нийгмийн нөхцөл байдлыг харгалзан үзэлгүй зөвхөн олж буй орлогод хөнгөлөлт, чөлөөлөлтийг нөхцөлт бусаар тодорхойлж байгаатай холбоотой байж болох юм.

Хувь хүний орлогын албан татварын чөлөөлөлттэй холбоотой асуудлыг Франц, Сингапур, Шинэ Зеланд, Словени, Финланд, АНУ, БНСУ, Болгар улсад хэрхэн зохицуулдаг талаар судлан үзлээ.

Хүснэгт 24. Албан татварын хөнгөлөлттэй холбоотой бусад улсын туршлага

Д/д	Улс	Татварын хөнгөлөлтийн төрөл /тоо/
1	Франц	1. Хүүхэд асрах хөнгөлөлт /хүүхэд асрагч, гэрийн ажилд туслах хүн хөлслөх/ 2. Эрчим хүчний шилжилтийн зардлын хөнгөлөлт 3. Сургуулийн зардал 4. Зөвшөөрөгдсөн тусламжийн байгууллагад үзүүлсэн хандивын тодорхой хувиар хөнгөлөлт үзүүлдэг.
2	Америк	1. Стандарт чөлөөлөлт *Ганц бие эсвэл гэрлэсэн тохиолдолд тус тусад нь 14,600 2. Хамт тайлагнасан болон эхнэр нөхрийн хувьд 29,200 3. Өрхийн тэргүүний хувьд 21,900 4. 65-аас дээш насны хасалт
3	Сингапур	1. Орлогын хөнгөлөлт 2. Гэр бүлийн хөнгөлөлт 3. Сургалтын төлбөрийн хөнгөлөлт 4. Тэтгэврийн хуримтлал 5. Хандивын хөнгөлөлт
4	Өмнөд Солонгос	1. Орлогын хөнгөлөлт 2. Гэр бүлийн хөнгөлөлт 3. Тэтгэврийн хуримтлал
5	Шинэ Зеланд	1. Хөдөлмөр эрхэлдэг бага, дунд орлоготой гэр бүлүүдэд татварын хөнгөлөлт үзүүлдэг. 2. Хандивын татварын хөнгөлөлт /хэрэв бүртгэлтэй хандивын байгууллагад хандив өгвөл жилд 1,500 хүртэл долларын хөнгөлөлт эдлэх боломжтой/
6	Словени	1. Орлогын хөнгөлөлт 2. Гэр бүлийн хөнгөлөлт 3. Тэтгэврийн хуримтлал
7	Финланд	1. Орлогын хөнгөлөлт 2. Ажилтантай холбоотой зардал 3. Ипотекийн зээлтэй иргэдийн зээлийн хүүгийн хөнгөлөлт 4. Зөвшөөрөгдсөн хандивын байгууллагад олгосон хандив 5. Гэр бүлийн хөнгөлөлт 6. Тэтгэврийн хуримтлал

8	Болгар	1. Хөдөлмөрийн чадвар алдсан хүнд зориулсан татварын хөнгөлөлт 2. Сайн дурын нийгмийн баталгаа, даатгалын хөнгөлөлт 3. Тэтгэврийн даатгалын хөнгөлөлт 4. Хандивын татвараас чөлөөлөгдөх 5. Залуу гэр бүлүүдэд зориулсан татварын хөнгөлөлт 6. Хүүхдүүдэд зориулсан татварын хөнгөлөлт 7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан татварын хөнгөлөлт 8. Бэлэн бус төлбөрийн татварын хөнгөлөлт 9. Үл хөдлөх орон сууцны сайжруулалт, засварт зориулсан татварын хөнгөлөлт 10. Фермерийн хөнгөлөлт
---	--------	--

Сонгон судалсан улс орнуудын татварын хууль тогтоомжид хувь хүнд үзүүлэх татварын хөнгөлөлт нь ихэвчлэн гэр бүлийн амьжиргааг дэмжихэд чиглэсэн гэр бүл, хүүхдэд хөнгөлөлт үзүүлэх зохицуулалтыг агуулж байгаа нь Монгол Улс судлан нэвтрүүлж болох сайн туршлага, оновчтой шийдлүүдийн нэг байж болох юм. Түүнчлэн, Франц, Сингапур, Шинэ Зеланд, Финланд улсуудад төрөөс зөвшөөрөгдсөн буяны байгууллагад хандив өгсөн тохиолдолд татварын хөнгөлөлт үзүүлдэг нь хүмүүнлэгийн санаачилгыг дэмжих зорилготой байна.

Олон улсын сайн жишиг болсон улсуудын туршлагаас харахад татварын тогтолцоо нь татварыг үр ашигтай цуглуулах, удирдахад гол анхаарлаа хандуулдаг бөгөөд татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалсан, нийгэмд чиглэсэн бодлогыг ихээр хэрэгжүүлдэг байна. Манай улсын хувьд хувиараа аж ахуй эрхлэгч нарыг дэмжих таатай орчин нөхцөл, бодлого, зохицуулалт хангалтгүй, мөн тэдгээрийн үйл ажиллагаанаас төлөх татварт оновчтой хөнгөлөлт, чөлөөлөлт байхгүй байгаа нь тэдгээрийн хөгжилд саад учруулж байна.

Түүнчлэн, эдгээр улсуудаас гадна Япон Улсын хувьд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь гэр бүл, ялангуяа хэн нэгнийг асран хамгаалдаг айл өрхөд санхүүгийн хөнгөлөлт үзүүлж, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, өндөр настнаа асрахтай холбоотой санхүүгийн ачааллыг бууруулахад чиглэдэг. Тухайн хүний гэр бүлийн нөхцөл байдал, онцгой шаардлага зэргийг харгалзан үзэж татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгох нь сайн дураар татвар төлөгчдөд хөшүүрэг болдгоос гадна татварын зохицуулах үүрэг зохих ёсоор хангагдаж, зорилтот бүлгээ дэмждэг байна. Мөн Япон улсад хөдөлмөрийн бүтээмж, мэдлэг ур чадвар, илүү цагаар хөдөлмөрлөх гэх мэт хүчин зүйлсийг хамруулан авч үзсэн тодорхой хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтыг хийсэн байдаг нь ажил эрхлэгчид өөрийн ХХОАТ-ын тайлангаа үнэн, зөв нээлттэй гаргахад эерэг нөлөө үзүүлдэг байна.

Мөн манай улсын цалин, хөдөлмөрийн хөлсний орлогын эх үүсвэрт хамруулж буй хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг бусад улсын туршлагатай харьцуулан харвал бодлогын чиглэл хангалттай тодорхой биш, урт хугацааны зорилтод нийцсэн зохицуулалт багатай, хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн онцлог, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс, нөөц бололцоог тооцоогүй гэх мэт хэд хэдэн зохицуулалтыг орхигдуулсан гэж хэлж болох юм.

Цалин, хөдөлмөрийн хөлсний орлогод ногдуулсан албан татварт үзүүлэх хөнгөлөлтийн хувийн жин нь нийт ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнд өндөр байгаа нь тухайн татварын зохицуулалтын үүрэг хангагдаж байна гэсэн үг биш бөгөөд Хувь хүний үйл ажиллагааны орлогод албан татвар бүрэн ногдуулж чадахгүй байгааг харуулж байна. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн талаар олон нийтийн зүгээс байнга шүүмжлэлтэй хандаж холбогдох саналуудыг дэвшүүлсээр ирсэн.

Түүнчлэн, зохицуулалтын үүргийн хувьд ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дамжуулан олон төрлийн бодлогыг хэрэгжүүлэх боломжтой ба үйл ажиллагааны орлоготой холбоотой дараах ХХОАТ-ын хөнгөлөлтүүд байна. Үүнд:

Дараах бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн болон тариалсан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө. Үүнд, үр тариа; төмс, хүнсний ногоо, түүний үр; жимс, жимсгэнэ, түүний үр, суулгац; тэжээлийн ургамал; модны суулгац хамаарч байна.

Үйл ажиллагааны орлогын төрөлд эдгээр орлогын эзлэх хувь нэмэгдэж байгаа хэдий ч тэдгээрийг бодит тоо баримтаар нотлох тооцоолол, судалгаа одоог хүртэл албан ёсоор хийгдээгүй байна. Иргэдийн дунд мөн эдгээр орлогын эх үүсвэрээс татвар төлөх тухай ойлголт хангалтгүй байгааг нийт ХХОАТ-ын дүнд үйл ажиллагааны орлогоос орж ирж буй сүүлийн 5 жилийн татварын орлого өсөөгүй байгаагаас харж болох юм.

Түүнчлэн, Татварын хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотойгоор хийгдэж буй уулзалт, хэлэлцүүлэг болон татварын албаны цахим тайлангийн систем, вэб хуудсаар дамжуулан татвар төлөгчдөөс ирж буй саналуудаас ХХОАТ-ын зохицуулалттай холбоотой саналыг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нэгтгэн авч үзэхэд нийт 30,018 иргэн ХХОАТтХ-ийн зарим зохицуулалтын талаар санал ирүүлсэн байна.

Үүнээс 614 иргэн Цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогод ногдуулсан албан татварын хөнгөлөлтийн хэмжээтэй холбоотой асуудлаар санал ирүүлсэн бөгөөд 320 буюу 52.1 хувь нь хөнгөлөх татварын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах, 138 буюу 22.5 хувь нь хөнгөлөх татварын хэмжээг амьжиргааны баталгаажих доод түвшин"-ий хэмжээтэй уялдуулах, 75 буюу 12.2 хувь нь хөнгөлөх татварын хэмжээг ам бүлийн тоотой уялдуулах, 62 буюу 10.2 хувь нь өрхийн нийт орлогын хэмжээтэй уялдуулах санал өгсөн байна.

Татвар нь төрийн зүгээс иргэд, хуулийн этгээдийн эд хөрөнгөд халдаж буй албадлагын шинжтэй үйлдэл тул татвар төлөгчийн хувьд татварыг зөвтгөж, хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэх нь туйлын чухал юм.⁹ Иймд аливаа татварын хувь, хэмжээтэй холбоотойгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа татвар төлөгчийн хувьд татварыг зөвтгөж, хүлээн зөвшөөрөх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн оновчтой арга замыг эрэлхийлэх нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. ХХОАТтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан албан татварын тайлан хүргүүлэх хугацаатай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Үнэлгээ:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долоо дугаар зүйлд иргэн бүр хуулиар ногдуулсан албан татвараа төлөх үндсэн үүрэгтэй гэж заасан байдаг. Харин иргэн олсон орлогоо өөрөө тайлагнан татвараа төлөх үүрэгтэй байдаг.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд Монгол Улсын иргэн, Монгол улсад 183 хоногоос дээш амьдран сууж байгаа гадаадын иргэд татвар төлөгч байна. Мөн

⁹ П.Одгэрэл, Татварын эрх зүйн ерөнхий анги /Захиргааны ерөнхий хууль ба Татварын ерөнхий хууль/, 2017 он, 13 дахь тал.

энэхүү хуулиар цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого, шууд бус орлого, бусад буюу урлаг спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, бичил худалдаа, ажил үйлчилгээний орлого, элдэв төрлийн сугалааны хонжвор гэсэн орлогуудад татвар ногдуулан төлдөг.

ХХОАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д “...Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1, 20.4-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ” гэж заасан бөгөөд тус хуулийн хоёрдугаар зүйлд хамаарагдах орлого олсон хувь хүн татварын тайлангаа гаргах үүрэг хүлээдэг.

ХХОАТХ-ийн 2020 оны хуулийн шинэчилсэн найруулгаар Хувиараа бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүнийг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагнах ажиллагааг хялбарчлах зорилгоор хялбаршуулсан татварын тайлагнал, төлөлтийн заалтуудыг баталсан. Үүний дагуу 50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой хувь хүн өөрөө хүсвэл нийт татвар ногдох орлогын 1 хувьтай тэнцэх татвар төлж, жилд нэг удаа тайлагнана гэж заасан

Монгол Улсын Их Хурлаас 2019 онд баталсан татварын хуулийн шинэчлэлд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, татварын орчныг хялбаршуулах зорилгоор хийгдсэн өөрчлөлтийн дагуу хувиараа бизнес эрхлэгчийн тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ нь 50.0 сая төгрөгөөс хэтрээгүй тохиолдолд өөрийн хүсэлтээр татварын хялбаршуулсан горимыг сонгож үйл ажиллагааны орлогынхоо нийт дүнгийн 1 хувиар албан татвар төлж, жилд 1 удаа тайлан гаргах боломжтой болсон.

Татварын хуулийн шинэчлэлийн үр дүнд нийт хувиараа бизнес эрхлэгчдийн хувь хүний орлогын албан татварын тайлагналт 2022 онд 2019 онтой харьцуулахад 28 хувиар өссөн байх ба нийт тайлангийн 59 хувь нь хялбаршуулсан горимоор тайлагнасан байна. Үүнээс харахад хувь хүний орлогын албан татварын тайланг хялбаршуулсан горимоор тайлагнах сонголтыг хувиараа бизнес эрхлэгчдэд олгосон шийдвэр нь татварын тайлагналтын хэмжээнд эерэг нөлөө үзүүлсэн нь харагдаж байна.

Хүснэгт 25. Бүртгэлд хамрагдсан татвар төлөгчийн тоо¹⁰
(2023.12.17-ны өдрийн байдлаар)

ТТ-ийн хандлага	ХХОАТ	ТТ-06	ХГ	НӨАТ	ҮХЭХАТ	НХАТ
Тайлант оны эхний үлдэгдэл	2,009,755	218,300	119,795	6,384	42,326	776
Тайлант онд нэмэгдсэн	2,085	85	61	2,416	9,855	125
Тайлант онд хасагдсан	295	2	13	1,298	135	11
Тайлант оны эцсийн үлдэгдэл	2,010,502	218,347	119,825	7,500	50,648	848
Хувь (өсөлт / бууралт)	0.5%	0.08%	0.07%	17.8%	5.4%	14.7%

¹⁰ TABLEAU, Татварын мэдээ судалгаа, статистикийн нэгдсэн систем

Татварын албанд 2,009,755 хувь хүн татвар төлөгчөөр бүртгүүлснээс 338,095 буюу 16.8 % нь үйл ажиллагааны орлоготой хувь хүн байна. Үйл ажиллагааны орлоготой татвар төлөгчийн тоо 2024 оны эхний 12 сарын байдлаар 146-аар нэмэгдсэн бөгөөд хувь хүний сегментийн татвар төлөгчийн 0.04 % нь шинэ татвар төлөгч байна.

Хүснэгт 26. Хугацаанд нь ирүүлсэн тайлангийн тоо, ногдол эзлэх хувиар (2023.12.31-ны өдрийн байдлаар)¹¹

№	Татварын тайлангийн төрөл	Ирүүлбэл зохих тайлан тоо	Ирүүлсэн тайлан тоо	Эзлэх хувь	Хугацаандаа ирүүлсэн тайлан тоо	Эзлэх хувь	“Х” тайлан тоо	Хугацаандаа ирүүлсэн тайланд эзлэх “Х” тайлангийн хувь
1	ХХОАТ /ТТ-06/	217,499	30,067	13.8	78	0.1	5,689	18.8
2	ХХОАТ/ХГ/	121,189	23,260	19.2	23	0.1	7,960	34.2
3	НӨАТ	4,847	4,818	99.4	4,033	83.2	1,211	30

Хүснэгт 27. Хугацаа хоцроосон тайлангийн тоо, эзлэх хувь (2023.12.31-ны өдрийн байдлаар)¹²

№	Татварын тайлангийн төрөл	Хоцорч ирүүлсэн тайлан тоо	Эзлэх хувь	Ирүүлээгүй тайлан тоо	Эзлэх хувь
1	ХХОАТ/ТТ-06/	29,989	15.7	187,279	59.5
2	ХХОАТ/ХГ/	23,237	10.7	97,880	57.0
3	НӨАТ	398	84.1	75	0.5

Хувь хүний сегментийн татвар төлөгчийн үндсэн 2 татварын төрлөөр хуулийн хугацаанд тайлагнасан түвшин дунджаар 55.1 хувь ба хуулийн хугацаа хоцроосон 32.5 хувь, тайлан ирүүлээгүй 39.0 хувийг тус тус эзэлж байна.

Дээрхээс дүгнэвэл, ХХОАТтХ-ийн 27 дугаар зүйлийн 27 .1 дэх хэсэгт заасан албан татварын тайлан хүргүүлэх хугацаатай холбоотой зохицуулалт практикт бүрэн хэрэгжихгүй байна. Энэ нь иргэдийн ХХОАТ төлөхтэй холбоотой татвараа хэрхэн тайлагнах, тооцоолох гэх мэт мэдлэг дутмаг байдал болон хууль хоорондын уялдаа холбоотой байдал хангалтгүй зэрэг шалтгаантай холбоотой байж болох юм. Тиймээс албан татварын тайлан хүргүүлэх хугацааг бусад хуультай уялдуулах өөрчлөх нь тус зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулахад чухал үр нөлөөтэй.

¹¹ Мөн тэнд.

¹² Мөн тэнд.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим зохицуулалтад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр хавсралтын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг үнэлгээ хийв.

Ийнхүү үнэлэхдээ тус хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогтой уялдуулан аргачлалд заасны дагуу “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал” гэсэн 2 шалгуур үзүүлэлтийг сонгон үнэллээ.

“Зорилгод хүрсэн түвшин шалгуур” үзүүлэлтийн хүрээнд ХХОАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсэгт заасан бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлоготой холбоотой зохицуулалт болон тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан албан татварын хувь, хэмжээтэй холбоотой зарим зохицуулалтыг сонгон судалсан болно.

Харин “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тус хуулийн 21 дүгээр зүйлд заасан албан татварын хувь хэмжээтэй холбоотой зохицуулалт /мөн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг/, 22 дугаар зүйлд заасан албан татвараас чөлөөлөх орлого, 23 дугаар зүйлд заасан албан татварын хөнгөлөлттэй холбоотой зарим зохицуулалтыг сонгон авч тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэллээ. Тус судалгааны ажлыг гүйцэтгэж, дараах дүгнэлтэд хүрэв.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. ХХОАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т заасан “бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого”-той холбоотой зохицуулалт нь тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.3.6, 21 дүгээр зүйлийн 21.4, 26 дугаар зүйлийн 26.2, 26.3-т заасан зохицуулалтуудтай харилцан уялдаатай зохицуулалт байна. Тиймээс ч тус зохицуулалтыг үнэлэхдээ хуулийн дээр дурдсан зохицуулалтыг судлан үзэх зайлшгүй шаардлагатай болсон бөгөөд дээрх хэд хэдэн зохицуулалтуудын хэрэгжилт хангалтгүй, эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа нь ХХОАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т заасан зохицуулалтын зорилгод хүрэх байдалд нөлөөлж байна гэж үзсэн болно.

Тодруулбал, бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, албан татварын хэмжээг тогтоох зохицуулалттай байхад 3 аймаг, нийслэлийн 9 дүүрэг тогтоогоогүй, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан болон аваагүй этгээдийн эрх зүйн байдал ижил байна. Өөрөөр хэлбэл зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага тодорхой бус, хяналтын механизм төлөвшөөгүй байдалтай гэх мэт шалтгаанаас тус зохицуулалтын практик хэрэгжилт хангалтгүй, зорилгодоо хүрээгүй нөхцөл байдал тогтоогдож байна.

2. Монгол Улсад хувь хүний орлогын албан татварт албан татварын хувь хэмжээг орлогын байдлаас, гэр бүлийн байдлаас, эрхэлж буй үйл ажиллагаанаас хамааруулан ялгавартай буюу шаталсан хувь хэмжээгээр тооцсоор ирсэн байна. Улсын Их Хурлаас “Дөрвөн арвын зарчим” гэж аж ахуйн нэгж, хувь хүний орлогын болон нэмэгдсэн өртгийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тус тус 10 хувь болгосноор 15 жилийн хугацаанд тогтмол хувь хэмжээгээр ногдуулж иржээ.

Манай улс ийнхүү цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод шаталсан хэмжээгээр албан татвар ногдуулж орлогоос хамааруулан шаталсан татварын бодлогоор дамжуулан иргэдэд ногдох татварын ачааллыг тэнцвэржүүлж байгаа нь олон улсын туршлагад нийцсэн орлогын тэгш бус байдлыг бууруулах замаар эдийн засаг, нийгэмд эерэг нөлөө үзүүлэхүйц зохицуулалт болжээ.

ХХОАТХ-д 6 төрлийн орлогыг татварын суурь үзүүлэлтэд хамруулан татвар төлөхөөр заасан ч ХХОАТ-ын орлогын 76-78 хувийг нь зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого бүрдүүлж байна. Энэ нь татварын шударга байх зарчмыг алдагдуулж байх магадлалтай. Учир нь бусад төрлийн орлого олсон хувь хүн татварт

хамрагдалт хангалтгүй байгаагаас үүдэн хувь хүний орлогын албан татварын ачаалал тогтмол ажлын байртай, хөдөлмөр эрхэлж буй хүмүүст илүү чиглэж байна.

Иймээс цаашид бусад төрлийн орлогод албан татварын шаталсан хувь хэмжээгээр татвар ногдуулах, нийт орлогод ногдох татвар тус бүрд тогтоосон хувь хэмжээгээр татварыг ногдуулсны дараагаар эцсийн төлбөл зохих татварт үнийн дүнгээс хамааруулан шаталсан тогтолцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Монгол Улсын хууль тогтоомжоор цалин, хөдөлмөрийн хөлсний орлогод ногдуулж буй хувь хэмжээ олон улсын дунджаас харьцангуй доогуур бөгөөд өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөлд тохирсон байна гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, ХХОАТтХ-ийн 21 дүгээр зүйлд заасан 21.1 дэх хэсэгт заасан энэхүү зохицуулалт практикт нийцэж буй боловч хүлээн зөвшөөрөгдөх байдлын хувьд хангалтгүй байгаа нь иргэдээс ирүүлж буй санал шүүмжээс харагдаж байна.

Мөн тус хуулийн 21.3-т заасан зохицуулалттай холбоотойгоор үйл ажиллагааны орлоготой хувиараа бизнес эрхлэгч хувь хүн санхүү, татвар болон эрх зүйн мэдлэг дутмагаас бүртгэлээ хэрхэн хөтлөх, орлого, зардал, татвараа тооцох, борлуулалтын орлого, хасагдах зардлаа өөрөө тооцож татвараа тайлагнах асуудал хүндрэлтэй байдгаас нийт борлуулалтын орлогод 1 хувиар тооцох хуулийн өөрчлөлт оруулсан боловч бизнес эрхлэгчид НӨАТ суутган төлөгч болохгүйн тулд орлогоо бага болгох, нуун дарагдуулах зорилгоор борлуулалтад төлбөрийн баримт олгохгүй байх сөрөг нөлөө үүсгэж байна.

Татварын албанд иргэн, хуулийн этгээдээс төлбөрийн баримт олгоогүй гэх гомдол 2021 онд 43,266, 2022 онд 33916, 2023 онд 24337, 2024 онд 18336 ирүүлснээс дийлэнх нь хувиараа бизнес эрхлэгч, бичил худалдаа эрхлэгч иргэд байна.

2. ХХОАТтХ-ийн 22, 23 дугаар зүйлд албан татвараас чөлөөлөх 9 заалт, албан татварын хөнгөлөлт үзүүлэх 12 заалт байгаагаас чөлөөлөлттэй холбоотой 9 заалт бүгд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бол хөнгөлөлтийн 1 заалтад орсон өөрчлөлтийг /23.10 Аймаг, хот, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн энэ хуулийн 6.3.2-т заасан орлогод ногдох албан татварыг аймаг, хот, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд 90 хувиар хөнгөлнө./-ыг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр байна.

Хуульд нийгмийн хамгаалал, боловсролыг дэмжих болон байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг хуульчилсан боловч зорилтот бүлэгт чиглэсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалт дутмаг, татвар төлөгч иргэдийн хувьд хангалттай биш гэж үзэж байна.

Иймд иргэдийн амьжиргааг дэмжих, байгаль орчны бохирдлыг бууруулах, улсын хөгжлийн хэтийн төлөвт нийцэхүйц нөхцөлт хөнгөлөлтийг бий болгож, шинээр хуульчлах шаардлагатай.

3. ХХОАТтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан зохицуулалтын дагуу татварын хөнгөлөлтөд хамрагдсан байдлыг судлахад, сүүлийн 4 жилд энэ төрлийн албан татварын хөнгөлөлт эдэлсэн талаарх мэдээлэл ТБМНС-д бүртгэгдээгүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газраас ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээг батлаагүйтэй холбоотой.

Мөн зүйлийн 23.4-т заасан албан татварын хөнгөлөлтийн зохицуулалтыг татвар төлөгч, иргэд хүлээн зөвшөөрч, практикт хангалттай хэрэгжин, зорилгодоо хүрч байгаа боловч Монгол Улсын инфляцын түвшин, орон сууцны үнийн өсөлт зэргийг тооцон тус зохицуулалтад заасан "...6 сая төгрөг хүртэл..." гэснийг тодорхой дүнгээр нэмж хуульчлах шаардлагатай гэж үзсэн болно.

Харин тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсэгт заасан зохицуулалт иргэд, олон нийтээс нэлээдгүй санал, шүүмж ирж байгаатай холбоотойгоор хүлээн зөвшөөрөгдөх байдал болон практикт хэрэгжих боломж хязгаарлагдмал байх эрсдэлтэй гэж таамаглаж байна. Иймд энэхүү зохицуулалтыг эргэн харах нь зүйтэй.

Нөгөөтээгүүр, олон улсын туршлагаас харвал татвараас чөлөөлөх, хөнгөлөх зохицуулалтууд нь ихэвчлэн гэр бүл, хувь хүний амьжиргааг дэмжихэд чиглэсэн байна. Иймд ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтыг илүү оновчтой, хэрэгжихүйц бөгөөд иргэний амьжиргааг бодитой дэмжих үр дагавартай байхаар боловсруулах, хөнгөлөлт чөлөөлөлтийн тоог бууруулах, үр дүнгүй практикт хэрэгждэггүй зохицуулалтыг хасах шаардлагатай.

4. ХХОАТтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан албан татварын тайлан хүргүүлэх хугацаатай холбоотой зохицуулалт практикт бүрэн хэрэгжихгүй байна. Энэ нь иргэдийн ХХОАТ-ын тайлангаа хэрхэн тайлагнах талаар мэдлэг дутмаг байдал болон хууль хоорондын уялдаа холбоотой байдал хангалтгүй зэрэг шалтгаантай холбоотой байж болох юм. Тиймээс албан татварын тайлан хүргүүлэх хугацааг бусад хуультай уялдуулах өөрчлөх нь тус зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулахад чухал үр нөлөөтэй.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. ХХОАТтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсэг практикт хэрэгжилт хангалтгүй байна. Иймд өөрчлөн найруулах шаардлагатай гэж үзэж байна.
2. Тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасан албан татварын хувь хэмжээтэй холбоотой зохицуулалт нь хууль батлагдах үеийн зорилтот түвшинд хүрээгүй, практикт хэрэгжих байдал сөрөг үр нөлөөтэй байх тул сайжруулах;
3. Тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын 240 мянган төгрөгөөс шатлалтайгаар бууруулан хөнгөлөлт эдлүүлэх зохицуулалтыг өөрчлөх, хөнгөлөлтийг тооцох суурь үзүүлэлтээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ сонгон тооцоолох, хөнгөлөлтийг буцаан олголт хэлбэрээр хийгддэг байхаар зохицуулах;
4. Тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалтыг хасах, эсвэл практикт илүү нийцсэн заалтаар сольж өөрчлөн найруулах;
5. Тус хуулийн 23.4 дэх заалтад буй "...6 сая төгрөг хүртэл..." гэснийг "10 сая төгрөг хүртэл..." гэж өөрчлөх.
6. Тус хуулийн 23.10 дахь заалтыг "Аймаг, хот, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд үйл ажиллагаа эрхлэгч албан татвар төлөгч иргэний энэ хуулийн 6.3.2-т заасан орлогод ногдох албан татварыг аймаг, хот, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд 90 хувиар хөнгөлнө" гэж өөрчлөн найруулах;
7. Тус хуулийн 27 дугаар зүйлд заасан албан татварын тайлан хүргүүлэх хугацааг оновчтой тодорхойлж, бусад хуультай уялдуулан өөрчлөн найруулах.

ТАВ. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2019), №23;
- Татварын ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2019), №22;
- Төсвийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2012), №03;
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”;
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн дугаар 181 тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;

Бусад эх сурвалж

- “Татварын шинэчлэл-2025” олон нийтийн санал, асуулга, хэлэлцүүлгийн нэгтгэл мэдээ
- TABLEAU, Татварын мэдээ судалгаа, статистикийн нэгдсэн систем
- П.Одгэрэл, Татварын эрх зүйн ерөнхий анги /Захиргааны ерөнхий хууль ба Татварын ерөнхий хууль/, 2017 он;
- Татварын тогтолцоо /Тэргүүн дэвтэр/, 2002 он;
- ХХОАТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга;